

Корона
Диана,
зүрх сэтгэлийн гүнж



Стефан БЕРН

Диана, зүрх сэтгэлийн гүнж
Зохиолч: С.Берн
Орчуулсан: А.Баасандорж

ISBN: 978-99929-4-298-3

© Энэхүү бүтээлийн эрх нь Монгол Улсын Зохиогчийн Эрхийн тухай хуулиар хамгаалагдсан болно. Бүтээлийг цахим хэлбэрээр түгээх эрхийг bookstore.mn цахим хуудас эзэмших бөгөөд зөвшөөрөлгүйгээр бүтнээр нь буюу хэсэгчлэн хувилах болон бусад ямар нэгэн хэлбэрээр олшруулах, ашиглахыг хориглоно.

www.bookstore.mn

Оршил бүлэг



Орчуулагчийн үг

Английн гүнж Дианаг мэдэхгүй хүн бараг байхгүй биз ээ. Сэтгэл татам инээмсэглэл, үзэсгэлэн гоо бие цогцос, энэрэн нигүүлсэхүйн үйл ажиллагаагаараа дэлхий нийтийн танил болсон тэрбээр автомашины золгүй ослоор таалал болсноос хойш 12 жил болж байна. Монгол ёсоор бол хүний амьдралын нэгэн мөчлөг өнгөрлөө гэсэн үг. Хэдийгээр эзэн нь байхгүй ч үйл хэрэг нь мөнхрөн, бас үргэлжлэн, алдар суу нь улам бадарсаар буй нь яах аргагүй бахдан дуу алдмаар бахархал мөнөөс мөн.

Түүний үхэл үнэхээр гэнэтийн байсан бөгөөд дэлхийн бүх орны шүтэн бишрэгчид нь гүн хямралд орсон юм. Тэрхүү хар өдрүүдэд уран бүтээлчид түүний дурсгалд зориулан сор бүтээлээ туурвиж, энгийн ард иргэд өөрийн улсад суугаа Английн Элчин сайдын яаманд очин эмгэнэл илэрхийлж байсан билээ. Чухамхүү тэр өдрүүдэд яруу найрагч Я.Бадамсүрэн үзгээ шүүрэн авч “Гүнж тогоруу” хэмээх дууны шүлгээ туурвисан байдаг.

Дорноос мандсан наран тогоруу

Доголон нулимс унагалаа, чи минь

Навчис будантаж гуниг ивэлдэгсэн

Наран эрт буцаж дээ, хорвоо минь

Гэрэлтэй насны гүнж тогоруу

Гэгээн залуу хайр минь баяртай

Дэндүү дэндүүхэн дурласан юм сан даа

Дээлийнхээ энгэрт нулимстай үдье дээ

Өмнөөс хөөрсөн саран тогоруу

Өнчин ганганаа нисгэлээ, чи минь

Салхи эзгүйрч намар ирдэг сэн

Саран эрт холдож дээ, хорвоо минь

Гэрэлтэй насны гүнж тогоруу

Гэгээн залуу хайр минь баяртай

Дэндүү дэндүүхэн дурласан юм сан даа

Дээлийнхээ энгэрт нулимстай үдье дээ

Зүрхнээс ниссэн цэн тогоруу

Зүүдэн бодлыг аргадлаа, чи минь

Шүүдэр солонгорч хяруу унадаг сан

Цасан эрт наашилжээ, хорвоо минь

Гэрэлтэй насны гүнж тогоруу

Гэгээн залуу хайр минь баяртай

Дэндүү дэндүүхэн дурласан юм сан даа

Дээлийнхээ энгэрт нулимстай үдье дээ

Түүний энэ шүлгэнд хөгжмийн зохиолч Б.Цэрэндондов ая зохиож, дуучин Н.Энхбат дуулж олны хүртээл болгосон байна. Яг үүн лүгээ адилаар нэрт дуучин Элтон Жон үзгээ шүүрэн авч “Английн сарнай минь үүрд баяртай” дуугаа зохиож, оршуулах ёслол дээр нь дуулсан юм. Энэ мэтчилэн гүнжийн дурсгалд зориулан хичнээн дуу, шүлэг, уран бүтээл төрснийг тооцох аргагүй билээ.

Дианаг эмгэнэлт ослоор цаг бусаар мөнхрөлийн оронд одсоноос хойш орчлон хорвоо дээр олон юм өөрчлөгдөж хувирчээ. Үйл хэргийг нь залгамжлах ёстой хоёр хүү нь хүдэр чийрэг эрс болцгоожээ. Нэгэн үе тоонотой гэрт толгой холбож, тостой тогоонд хошуу дүрж явсан Галлын хунтайж Чарльз тухайн үед нууц амраг нь байсан Камилла Паркер Боулзтайгаа ханилан суужээ.

Гүнжийн сууж явсан машины ослын талаарх хэргийн шалгалт үндсэндээ дуусчээ. Гэвч олон

хүн ослын үнэн мөнийг зөв тогтоож чадаагүй гэж үзэн сэтгэл гонсгор явдаг, түүнийгээ ч хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр байнга илэрхийлдэг болсоор удаж байна. Энэхүү эмгэнэлт ослын үеэр хүүгээ цаг бусаар алдсан Египетийн тэрбумтан Мохаммед Аль Файед ослын жинхэнэ үнэнийг олж тогтооход хатан хааны гэр бүлийнхэн саад хийсээр санасандаа хүрсэн гэж үзсээр буй. Тэрбээр гүнжийг захиалгат аллагад өртсөн, түүний золионд хүү нь бас амиа алдсан гэсэн хатуу байр суурьтай байгаагаа үе үе илэрхийлдэг.

Гүнжийг нас барахад хатан хаан хийгээд Бэкингэмийн ордныхны баримталж байсан сонирхолтой байр суурийн талаар Холливудад “Хатан хаан” хэмээх нэртэй, шуугиан дэгдээсэн кино бүтээж, гол дүрд нь тоглосон жүжигчин Хелен Миррен “Оскар”-ын шагнал хүртэж байсныг бид мэднэ. Цаашдаа гүнжийн эмгэнэлт үхлийн талаар уран сайхны кино бүтээх хэтийн санаа Холливудынханд байгаа юм гэсэн.

Тэгвэл дэлхийн хүмүүсийн зүрх сэтгэлийн гүнж байсан Дианагийн талаар амьд ахуйд нь ч, нас барсан хойно нь ч маш олон ном хэвлэгдэн гарчээ. Тэдний олонх нь ашиг орлогын хойноос хөөцөлдсөн, ор дэрний жижиг асуудал сөхсөн, худал хуурмаг мэдээлэл зохиомжоор дүүрсэн номонцорууд байсан юм.

Харин Францын нэртэй сэтгүүлч Стефан Бернийн энэхүү бэсрэг ном үнэнд хамгийн ойрхон бүтээл болсон гэж олон нийт үздэг юм. Үргэлж инээмсэглэж явдаг үзэсгэлэн төгс бүсгүй яг жинхэнэ амьдрал дээрээ ямархуу жаргал зовлон туулсныг үнэн баримттайгаар, ямар ч уянгын нэмэр хачир, дэгсдүүлэлгүйгээр өгүүлснээрээ энэ номын үнэ цэнэ хэзээ ч алдагдахгүй юм. Тиймийн учир энэхүү бэсрэг номыг монгол уншигчдадаа зориулан франц эх хэлнээс нь чадан ядан орчуулан толилуулж байна. Та бүхний таалалд нийцэх буй заа.

Эцэст нь номын зохиогч Стефан Бернийн талаар хэдэн үг хэлье. Тэрбээр 1963 оны арваннэгдүгээр сарын 14-нд Лион хотноо төржээ. Лионы худалдаа эдийн засгийн дээд сургуулийг төгссөн тэрбээр багын авьяас билэгтээ тулгуурлан сэтгүүл зүйд хүчээ сорих болсон байна. Тэглээ гээд, мэргэжлээ солилоо гээд тэр алдаагүй юм. Одоо С.Берн Францын телевиз, радио, сонины нэртэй сэтгүүлч болж нэгэнт чаджээ. Тэрбээр баримтат уран сайхны 10 шахам ном туурвиснаас хамгийн их амжилт олсон нь энэхүү “Зүрх сэтгэлийн гүнж” болой. Энэ ном олны сэтгэлд хүрч чадсаны нэг нууц нь сэтгүүлч С.Берн хунтайж Чарльз болон гүнж Дианатай дотны танилууд байсанд оршдог юм.

Орчуулагч. 2008.11.01.

Тэргүүн бүлэг



Бага, Өсвөр нас

Түүний амьдрал шидэт үлгэрт өгүүлдэг гүнжийн түүхийг санагдуулдаг юм. Цэвэр ариухан сэтгэлтэй жаахан бүсгүйд Английн хунтайж зүрх сэтгэлээ өгсөн нь үнэхээр гайхамшиг билээ. Хааны удмын цус түүний судсаар гүйж байсан болохоор Виндзорын ордонд хөл тавих хувь заяа тохиосон ч байж болох юм. Дианагийн удам судрыг хөөн үзвэл Английн хаан байсан Шарль II /1630-1690/-той нягт холбогдоно. Бүр дээд өвгийг нь нарийн судалбал, Их Британийн хаан Жэймс IV /1566-1625/-ээс удам судрын түүх нь эхэлдэг. Харин Дианагийн эхийн талынхан ирланд, швед цус холилдсон хүмүүс байв.

Дианагийн өвөө нь Харвардын их сургуулийг төгссөн нэгэн байсан бөгөөд дэлхийн нэгдүгээр дайны үеэр Францын армийн бүрэлдэхүүнд багтаж, америкчуудын эсрэг тэмцэж явжээ. Тэрбээр 46 настайдаа швед гаралтай, 20-хон настай үзэсгэлэнт бүсгүй Рут Сильви Жилтэй ханилан суужээ. Хос хоёр өмнө нь хааны эзэмшилд байсан “Парк хауз”-д суурьшихаар шийдсэн байна. Чухамхүү энэ харшид, 1936 онд тэдний хоёр дахь охин Франсис Рут Рош мэндэлжээ. Энэ бол Дианагийн ээж болох тавилантай хүмүүн байлаа. Харин түүний эцэг Эдвард Жон-Жонни-Спенсер 1926 онд төржээ. Тэр үед Английн чинээлэг айлын хүүхдүүд бүгд л Этоны коллежид суралцаад, дараа нь Хааны цэргийн академид элсэцгээдэг байв. Дианагийн эцэг Спенсер энэ замыг дагасан байна.

1953 онд Алторпын дэд гүн Спенсер 18 настай Франсис Рут Роштой танилцаж, сэтгэлийн жолоо алдуурчээ. Бие биедээ ухаангүй дурласан залуу хос тун удалгүй буюу 1954 оны зургадугаар сард хуримаа хийж, бал сараа тэмдэглэсэн байна. 1957 онд тэд “Парк хауз” харшид амьдран суухаар иржээ. Энэ харш үнэхээр тохилог бөгөөд зөвхөн унтлагын өрөө гэхэд л 10 байж. Усан сан, крикетийн болон теннисний сайхан талбайтай байлаа. Залуу хос энд цагийг зугаатай сайхан өнгөрүүлдэг байв. Гэвч 1959 онд тэдний гэр бүлд харамсалтай явдал тохиолдлоо. Спенсерийн гэргий Франсис нөхөртөө хүү төрүүлж өгсөн хэдий ч хүүхэд нь тэр өдрийнхөө орой нас баржээ. Энэ явдал тэдний аз жаргалтай гэр бүлд хүнд цохилт боллоо.

Өмнө нь тэд хоёр охинтой болоод байсан юм.

Үхэл хагацлаас ч болсон уу залуу хосын харилцаанд сэв сууж эхлэв. Гэвч хувь заяаны азтай тохиолдлоор тэд дахин хүүхэдтэй болжээ. Гэргий нь 1961 оны долдугаар сарын 1-нд гурван килограмм 500 грамм жинтэй охин төрүүллээ. Энэ бол ирээдүйд Английн гүнж болох хувь тавилантай Диана байв. Хуучны харамсалтай явдлаасаа сургамж авсан тэд охинтой болсноо долоо хоногийн турш бусдаас нуужээ. Охины бие сайн, их сэргэлэн цовоо байсан тул тайвширсан эцэг, эх нь удалгүй олон түмэнд шинэ хүнтэй болсноо зарласан байна. “Диана багадаа маш их эелдэг, нэг тийм үгээр илэрхийлэхийн аргагүй зөөлөн хүүхэд байсан” гэж тэдний хөрш байсан Гертруд Аллен дурсан өгүүлсэн байдаг. Хожим нь Диана нэг дүүтэй болсон юм.

Гэвч Диана болон түүний эгч, дүү нарыг нэгэн хүнд цохилт хүлээж байлаа. Энэ бол эцэг, эх хоёрынх нь салалт байв. “Бидний хамт амьдарсан он жилүүдийн хэд нь аз жаргалтай өнгөрснийг би мэдэхгүй байна. Цаг ямагт би “Энэ янзаар бол бид удаан хамт амьдарч чадахгүй юм байна даа” гэж боддог байлаа. Манай гэр бүлд өдөр ирэх тутам баяр баясгалан гэж байхгүй болсоор байсан юм. Бид нэг нэгнээсээ сэтгэл зүрхээрээ алгуурхан холдоцгоож байлаа” гэж тэр үеийнхээ тухай эцэг Спенсер өгүүлсэн байдаг.



Яг тэр үед хатагтай Франс романтик дурлалд автжээ. Түүний дурласан хүн нь Эдинбургийн их сургуулийн дипломтой, 42 настай Петр Шан Кидд гэгч байв. Түүний эцэг, эх нь Австрид хонины аж ахуйтай, бас бичгийн хэрэгслэлийн худалдаа эрхэлдэг хүмүүс байлаа. Ингээд хайр дурлалдаа шатсан хатагтай Франс “Парк хауз” дахь гэрээ орхин Белгравиагийн хороололд байр хөлслөн дурлалт хүнтэйгээ амьдрахаар оджээ. Энэ явдал Дианагийн хүүхэд насанд гүнзгий шарх үлдээсэн бөгөөд “Ээжийн суусан машины хөдөлгүүрийн дуу алгуурхан холдсоор чимээгүй болсон үеийг ердөө мартаж чаддаггүй” гэж хожим нь дурсан ярьсан

байдаг. Энэ үед тэр зургаахан настай байлаа. “Салах үедээ ээж уйлж, аав ганц ч үг дуугараагүй. Би яагаад салж байгаа тухай нь асуух гээд чадаагүй. Хүмүүс ямар муухай хувирамтгай байдгийг тэгэхэд л би ойлгосон” гэж Диана мөн дурсдаг байжээ.

Хэдийгээр ээж нь хүн дагаад одсон ч Диана, дүү Шарлийнхаа хамт эцэг, эхийнхээ хооронд гурван сар ирэн очин байлаа. Ингэсээр 1967 оны шинэ жилтэй золгож, бүх гэр бүлээрээ тэмдэглэжээ. Энэ үеэр Шан Кидд “Бид гэрлэлтээ бүртгүүлмээр байна. Тиймээс та салах гэрээнд гарын үсэг зурахгүй юу. Хүүхдүүдийг ч хэний асрамжинд үлдээхийг шийдмээр байна” хэмээн хэлжээ. Эцэг Спенсер ганц ч үг дуугарсангүй.



Диана дүү Чарльзийн хамт

Тиймээс Дианагийн ээж хүүхдүүдээ өөрийн асрамжинд авахын тулд шүүхэд хандлаа. Энэ үеэс тэдний гэр бүлийн амьдрал сонин хэвлэлийнхний анхааралд орж ирэв. 1968 оны зургадугаар сараас шүүх ажиллагаа эхэллээ. Удтал маргаан өрнөж, 1969 оны дөрөвдүгээр сард Спенсер, Франс хоёрын гэрлэлтийг албан ёсоор цуцаллаа. Энэ явдлаас хойш нэг сарын дараа хатагтай Франс, Петр Шан Киддтэй гэрлэв. Тэд Ишнорт томоохон цэцэрлэгтэй байшин худалдаж авчээ.

Диана “Парк хауз”-д эцэг дээрээ үлдэв. Эхний хэдэн сард Диана ээждээ гомдож, шөнө орондоо ганцаараа уйлж тайтгардаг байлаа. Аав нь түүнийг хааяа ферм рүү дагуулан явж, гэрийн тэжээмэл болон зэрлэг амьтад үзүүлж сэтгэлийг нь засахыг оролддог байв.

Гэсэн ч тэр маш их ганцаардаж байлаа. Хэдийгээр тэр Кингс Лин дэх Ситфиелдийн сургуульд орж, олон хүүхэдтэй танил болсон ч ганцаардлаас ангижирч чадсангүй. Тэр уйтгар гунигаасаа салахын тулд уран зураг оролдож, усанд сэлэлтээр хичээллэх болжээ.

Дианаг есөн настай байхад ээж нь түүнийг “Харродс” их дэлгүүр рүү дагуулан явжээ. Диана Ридлесвортын сургуульд шилжин суралцах болсон тул түүнд шинэ хувцас авч өгөх гэж тийн

явсан хэрэг. Ээж нь саарал хүрэм, саарал банзал, час улаан малгай түүнд авч өгчээ. “Та надад хайртай байсан бол намайг орхиод явахгүй л байсан” гэж тэгэхэд Диана ээждээ хэлэх гэж хичээсэн боловч чадаагүй гэдэг.

Диана аав, ээжийнхээ салалттай ерөөсөө эвлэрч чадахгүй байлаа. Ридлесвортын сургуулийн захирал Элизабет Ридсдал /Ридди/ 120 сурагчийнхаа дунд нэгэн гэр бүл шиг уур амьсгал бий болгохыг хичээдэг хүн байлаа. Тиймээс ч Диана өөрийн энэ хоёр дахь “гэртээ” очих тун их дуртай байсан юм. Энд тэр усанд сэлэлт, бүжгийн дугуйланд явж эхэлсэн байна. Тэр бас хуучны зарим найзтайгаа ч энд уулзжээ. Диана хэл бичиг, тооны хичээлдээ гаргууд байсан бөгөөд түүнийг сургуулийн захиргаанаас хэдэнтээ урамшуулан шагнаж байсан удаатай.



*Гүн Эдвард Жон Спенсер хоёрдахь гэргий Райны хамт Алторн дахь шилтгээнийхээ өмнө.
Доод зурагт шилтгээний зочид хүлээж авах танхимын дотоод хэсгийг харуулжээ.*



Диана Лондонгийн гудамжинд алхаж яваа нь. 1980 оны арваннэгдүгээр сар

Тэр энд хоёр охинтой ихэд дотны найзууд болжээ. Эхлээд Каролин Придтэй дотноссон бол хэдэн сарын дараа Каролин Бартолмьютэй найзлах болсон байна. Хэдийгээр Диана усанд сэлэлтээр хичээллэх дуртай байсан ч гэр бүлийнхэн нь дургүйцэж байлаа. “Нэг л өдөр живчих ч юм бил үү” гэж ээжийнх нь ээж түүнд хэлсэн нь Дианагийн сэтгэлд хүнд тусав. Түүнээс хойш тэр ганцхан бүжгийн дугуйландаа явах болжээ. “Би сонгодог бүжигт их дуртай байлаа. Тиймээс мэргэжлийн бүжигчин болохыг маш их хүсч байв. Харамсалтай нь би өдөр

ирэх тутам улам өндөр болж, энэ мөрөөдлөө таягдан хаяхаас өөр аргагүй болсон” гэж Диана хожим нь дурсан ярьсан байдаг.

Яг энэ үеэр буюу 1975 оны зургадугаар сарын 9-нд, гэргийгээ нас барснаас хойш гурван оны дараа Спенсерийн удмын долоо дахь гүн, бүр тодруулж хэлбэл, Дианагийн өвөө таалал төгслөө. Энэ явдал тэдний гэр бүлд шинэ өөрчлөлт авчрав. Тэднийхэн Алторпын шилтгээнд нүүн ирж, эцэг Спенсер аавынхаа гүн зэргийг өвлөн авах нь тодорхой байсан тул түүний дэд гүн зэрэг Диана, эсвэл түүний дүү Шарльд уламжлагдах нь ойлгомжтой байлаа. Тэдний эзэмшилд 12500 га газар, маш ховор, бас асар үнэтэй уран зургийн цуглуулга шилжин ирэв. Мөн өв залгамжлах гэрээслэлийн дагуу 2250000 фунт стерлингийн бэлэн мөнгө тэдний гэр бүлийнхэнд өвлөгджээ.

Гүн Спенсерийг нас барснаас хойш нэлээд хугацаа өнгөрсний дараа хүү Спенсер дөрвөн хүүхдээ ээжтэй болгохоор шийдэв. Түүний хайрыг татсан хүн нь роман зохиогч Барбара Картландын охин, Дартмундын гүн Райн байлаа. Райны хувьд дөрвийн дөрвөн хүүхэдтэй хэл амаа ололцоно гэдэг маш хэцүү санагдаж байв. Гэвч тэр эцэст нь Спенсерийн гуйлтыг хүлээн авчээ. Тэд 1977 оны долдугаар сарын 14-нд ханилан суусан байна.

Харин Диана аавыгаа шинэ эхнэр авсанд ихэд дургүйцсэн бөгөөд хичээлдээ огцом муудаж, хэд хэдэн шалгалтад муу дүн авав. Иймээс түүнийг эцэг нь сургуулиас нь гаргажээ. Удалгүй Диана урлагийн менежер, загвар зохион бүтээгч, хоолны технологичийн мэргэжил эзэмшүүлдэг курст явах болжээ. Энд тэр Софи Кимбал гэдэг бүсгүйтэй ихэд дотно нөхөрлөж, өдрийн ихэнхийг түүнтэйгээ чалчиж өнгөрөөдөг болов. “Тэр их сонин сэтгэлгээтэй бүсгүй байсан. Дандаа шинэ, сонин санаа гаргана. Сайн мэдлэгтэй болж аваад хүүхдүүдийг сурган хүмүүжүүлэх ажилд хүчээ сорино. Дараа нь гэрлэж олон хүүхэд төрүүлнэ гэж тэр ярьдагсан. Энэ нь надад бас их нөлөөлсөн байх аа” гэж Диана найзынхаа тухай ярьсан байдаг.

1978 онд Швейцарьт хэдэн долоо хоногийг амралтын маягаар өнгөрөөсөн Диана Англидаа эргэж ирэнгүүтээ Лондонд суурьшиж, ажил хийхээр шийдсэнээ эцэгтээ дуулгав. Аав нь ч зөвшөөрөв. Архи ууж, тамхи татдаггүй үлгэр жишээч бүсгүйд ажил олгогч хоёр ч агентлаг хүүхэд асрах, гэр бүлийн хүрээнд баяр тэмдэглэж байгаа айлд үйлчлэгч хийх, гэр орон цэвэрлэх зэрэг түр зуурын хэд хэдэн ажил санал болголоо.

Харин Диана бүжгийн багшаар ажиллахыг хүсч байв. Азаар тэр Бетти Ваканийн студид сургагч багшаар ажиллах санал хүлээж авлаа. Ингэж түүний Лондон дахь амьдрал сэтгэл дүүрэн эхэлсэн байна. Тэр эмэг эхийнхээ түүнд гэрээслэн үлдээсэн хөрөнгөнөөс 50 мянган фунт стерлинг гаргаж, гурван өрөө байр худалдаж авчээ. Тэрбээр энд өөрийн дотны найз Каролин Бартолмью, Софи Кимбал, Филипа Коакер нартай хамт амьдрах болов. Түүнтэй Этоны сургуульд сурч байсан найз нар нь, амрах үедээ цанаар гулгаж яваад танилцсан нөхөд нь, бас хамгаалалтын ажилтнууд түүний гэрт байнга ирж буцаж байдаг байжээ.

Ийнхүү 1979 оны хавар хүртэл Дианагийн хувьд нэгэн хэвийн амьдрал үргэлжлэв. Харин тэр хавар, бүр тодруулж хэлбэл, хоёрдугаар сард Сандринхэмийн ордонд болох нэгэн үдэшлэгт Диана уригджээ. Энд түүний бүх амьдралыг өөрчлөх нэгэн үйл явдлын сэжүүр тавигдсан түүхтэй.

Дэд бүлэг



Эрин зууны гэрлэлт

Хунтайж Чарльз, Диана хоёрын танилцсан түүх хүн бүхний анхаарлыг татдаг. Тэд нээрээ яаж танилцсан юм бол оо. Спенсерийнхэн болон Виндзорын ордныхон Сандринхэмийн газар нутагт оршин суугчдаас хамгийн сайн хөршүүд байсан нь нөлөөлсөн гэдэгтэй олон хүн санал нийлдэг. Тэднийг үдийн цай хамт ууж, заримдаа бассейнд сэлэхээр явдаг байсан гэж ярьцгаадаг. Гэхдээ жинхэнэ түүх арай өөр байжээ.

28 нас дөнгөж хүрээд байсан, эзэн хааны титмийг өвлөн авах эрхтэй Чарльзыг 1977 оны намар хатагтай Сара Спенсер Алторпын эдлэн нутагт хийх ан авд оролцоно уу хэмээн урьжээ. Ийнхүү хөдөө талд, нэг их хүйтэн өдөр Чарльз, Диана хоёр бие биенээ анх харжээ. Нэн удалгүй үзэсгэлэнтэй, хөгжилтэй Дианад сэтгэл алдарсан Чарльз түүний эгч Сарагийн зочлох далим гаргаж тэднийд иржээ. 16 настай Дианагаас тэр харц ер салгахгүй байсан агаад тэднийд ихэд удаан саатжээ. Тийн сууж байснаа Алторпын ордны зургийн үзэсгэлэнг сонирхоход нь газарчилж, тайлбарлаж өгөхийг Дианагаас гуйжээ. Сара тэднийг сайтар танилцуулна гэж бодож байсан ч хунтайж ийнхүү санаачилгыг гартаа авсан байна.

Үүнээс хойш хоёр жилийн дараа хунтайж Чарльз 30 насныхаа төрсөн өдрийн баярыг Бэкингэмийн ордонд тэмдэглэхдээ Дианаг эгч Сарагийнх нь хамт урьжээ. Дианагийн амьдралыг бүхэлд нь өөрчлөх энэхүү нэр хүндтэй урилгыг хүлээж авах хүртэл тэд Сандринхэмийн газар нутагт долоо хоногийн амралтын өдрүүдээр хааяа зохиодог ан авын үеэр тааралдаж, хэдэн үг солилцдог байлаа. Хааны ордныхон хөөрхөн, залуухан Дианад элэгсэг сайхан ханддаг байв. Чарльз Дианад үнэхээр их дурласан байлаа. Харин Диана жаахан байсан болохоор тэр бүхнийг төдийлөн анзаардаггүй байв.

Бэкингэмийн ордонд Дианаг уригдан очсоноос хойш хэдэн сар өнгөрсний дараа бас нэг аялалд хамт явах саналыг Чарльз түүнд тавьжээ. Бямба, ням гаригийн амралтаараа Швейцарьт аялах санал мэдээж Дианад таалагдлаа. Аяллын үеэр тэд нэлээд дотносож, хоолны үеэр тэр хоёр булангийн ширээнд зэрэгцэн суучихсан байх нь олонтаа болов. Энэхүү

аяллаас эргэж ирснээс хойш тэд байн байн уулзалдах болсон байна.



Чарльз, Диана хоёр Балморалд. 1981 оны тавдугаар сар



Чарльз, Диана хоёрын сүй тавьсныхаа дараа авахуулсан анхны албан ёсны зураг. 1981 оны хоёрдугаар сарын 24.

1980 оны наймдугаар сард тэд бүтэн долоо хоногоор аялалд явахаар ярилцжээ. Энэ удаа Чарльз хэд хэдэн найзаа дагуулж явжээ. Тэд “Британниа” гэдэг хөлөг онгоцоор аяллаа эхэлсэн бөгөөд Дианагийн хувьд энэ аялал жаахан гунигтай болсон байна. Учир нь Чарльз Дианагаас 12 насаар ах тул түүний найзууд ч бас тиймэрхүү насны хүмүүс байв. Тиймээс 20 ч хүрээгүй жаахан охин тэдэнтэй яриа нийлэхгүй нь тодорхой байлаа. Хүмүүс хөгжилдөж байхад Диана тэднийг нүднийхээ булангаар ажиглан чимээгүйхэн сууж байдаг байжээ.

Гэвч энэ үеэс тэдний хайр сэтгэлийг улам бэхэжсэн гэдэг. Диана өдөр болгон сарнай цэцэг хүлээж авах болж, жинхэнэ мөрөөдлийн амьдралд умбаж эхлэв. Үүнээс хойш удаагүй байтал

Түүнд бас нэг сорилт тулгарлаа. Хунтайж өөрийн гэр бүлийнхэнтэйгээ хамт Шотландыг зорихдоо Дианаг авч явжээ. Виктория хатан хааны үед буюу 1848 онд худалдаж авсан Балморалын шилтгээнд тэд хэдэн өдрийг үдлээ. Хатан хаан болон түүний бараа бологчидтой хамт яваа болохоор ордны дэг жаягыг хатуу баримтлах шаардлага Дианад тулгарч байв. Гэхдээ л Чарльз тэр хоёр цагийг зугаатай өнгөрүүлж байлаа. Тэд Ди голын эргээр зугаалж, орой нь гадаа мах шаран удтал ярьж суудаг байв.

Хунтайж Чарльзтай найзлах болсон нь хувийн амьдралд нь цоо шинэ өнгө төрх, бас бэрхшээл зовлон авчирна гэдгийг залуухан Диана эхлээд сайн ойлгохгүй байлаа. “Хунтайж Чарльзын нууцлаг найз хэн бэ” гэсэн утгатай өгүүлэл сонинуудад нийтлэгдэх болж, папарацци нар түүнийг “ангуучилж” эхэлсэн үеэс л тэр бүхнийг ойлгожээ. Лондонгийн гудамжаар тааваараа алхаж, хүссэнээ хийдэг байсан дэндүү эрх чөлөөт үе өнгөрснийг тэрбээр мэдэрсэн байна. Сүүлдээ Дианагийн алхах гишгэх хүртэл бөөн хариуцлага болж хувирлаа. Сонинууд Дианагийн намтар түүхийг элдвээр хачирлан нийтэлж, түүнийг өглөө босоход нь телевиз, сонины сурвалжлагчид, папарацци нар байрных нь гадаа аль хэдийнэ ирчихсэн хүлээж байдаг байв. Зарим нь бүр цэцэрлэг дотор нуугдчихсан хэвтэж байх нь олонтаа. Дианагийн цагаан ноосон цамцтай, Лондонгийн гудамжаар алхаж яваа зураг сонинд хамгийн анх хэвлэгджээ. Дианагийн үзэсгэлэнтэй гоё царай, урт сайхан хөлийг магтсан янз бүрийн мэдээллүүд шар, бор сонины эхний нүүрээс нэг хэсэгтээ салсангүй.

Дианагийн гэнэн цагаахан зан британичуудын хайр, талархлыг эхнээсээ л хүлээж эхэлжээ. Өдөр ирэх тутам түүнийг үнэлэх үнэлэмж өссөөр л байлаа. Гэхдээ бүх юм дардан шулуун байгаагүй юм. Дианагийн ээж Франс Шан Киддын охиныхоо сонголтод эгдүүцсэн хилэнт захидал, хунтайж тэр хоёрыг салгах гэсэн оролдлогыг Бэкингэмийн ордноос гүтгэлэг хэмээн үзэж байлаа. Бас ард түмэн Дианаг заавал хунтайжийн гэргий болох ёстой гэсэн сэтгэл зүйд автаж эхэлжээ. Хэвлэлийнхэн үүнийг нь аятайхан хөөргөдөж байв. Энэ үед Диана, Чарльз хоёрын харилцаа гүнзгийрч, нууцаар уулзалдах нь олширчээ.

Мөн хатагтай Дианаг сэтгүүлчид мөрдөх нь улам ихсэж, аргагүйн эрхэнд тэрбээр гудамж руу харсан цонхтой байраа солиход хүрэв. Хунтайж Чарльз “Хамгийн дотны найз минь” хэмээн Дианад танилцуулсан Камилла Паркер Боулзын талаар ч бас хэвлэлийнхэн янз бүрийн зүйлс бичих боллоо. Чарльз, Камилла хоёр бие биедээ хайртай, түүнийгээ чанд нууцалдаг хэмээсэн нийтлэл ч гарав. Энэ бүхнийг уншиж сонссон Дианагийн хоёр эмээ хайртай охиндоо хунтайжтай гэрлэх хэрэггүй гэж хэлжээ. Гэвч Диана хариуд нь “Энэ бол маш хэцүү, бараг боломжгүй асуудал болсон” гэж хариулжээ. Энэ үед ард түмэн болоод хатан хааны гэр бүлийнхэн ямар нэгэн шийдвэр гаргах хэрэгтэй хэмээн Чарльзад шахалт үзүүлж байлаа. Хатан ээж нь түүнээс “Нэг бол хурдан гэрлэ, үгүй бол Дианагаас харилцаагаа тасал” гэж шаардах болов.



Чарльз, Диана хоёр хуримын ёслолынхоо дараа Бэкингемийн ордны тагтан дээрээс цугласан олонтой мэндчилж байгаа нь.

Швейцарийн Клостерт цанаар гулгаж амраад ирснийхээ дараа Чарльз Виндзорын ордонд Дианаг урьж, хэд хэдэн чухал зүйл ярих хэрэгтэй байна гэжээ. Ийнхүү 1981 оны хоёрдугаар сарын 6-ны баасан гаригт Галлын хунтайж Чарльз эхнэрээ болохыг Дианагаас гуйж зөвшөөрсөн хариу авчээ. Хунтайж Чарльз “Би түүнд миний саналыг тухтай, сайн бодож үзээрэй гэж хэлсэн. Гэтэл тэр дор нь хариу өгчихсөн” гэж хожим нь дурссан бол Диана “Надад тэр үед эргэлзэж тээнэгэлзээд байх зүйл байгаагүй” гэж хэлсэн байдаг. Ийнхүү Дианад үлгэрийн гүнжид тохиолддог шиг хувь тавилан оноогдсон юм.



Хатан хаан Элизабет, Гүн Спенсер нар гэрлэх ёслол болсон Гэгээн Полын сүмээс буцаж яваа нь.

Үүнээс хойш үйл явдал түргэн өрнөлөө. Арваадхан хоногийн дараа буюу 1981 оны хоёрдугаар сарын 24-ний үд дунд Бэкингэмийн ордноос нэгэн сайхан мэдээг хэвлэлийнхэнд дамжууллаа. Хатан хааны хэвлэлийн нарийн бичгийн дарга сонин, телевизийнхэнд хандан “Эдинбургийн бэйс, хатан хаан хоёрын хүү, Галлын хунтайж Чарльз, гүн Спенсер, хатагтай Шан Кидд нарын охин Диана Спенсертэй сүй тавилаа” гэж мэдэгджээ. Британийн хэвлэлүүд үүнийг үнэхээр гайхамшигтай үйл явдал хэмээн нэрлэж, тэдний хайр сэтгэл үргэлж бадарч явах болтугай гэсэн сайхан ерөөлийг хамтатган дэвшүүлж байлаа. Сүй тавьсныхаа дараа Бэкингэмийн ордны цэцэрлэгт хамтдаа авахуулсан албан ёсны анхны зураг нь бүх сонин, хэвлэлийн тэргүүн нүүрийг чимсэн байв.

Хунтайж Чарльз сүй тавьсны бэлэг тэмдэг болгож, 14 очир алмаасан шигтгээтэй, 314 мянган франкын үнэтэй бөгжийг хатагтай Дианагийн ядам хуруунд зүүж өгчээ. Тэдний сүй тавьсныг британичуудын 73 хувь нь дэмжиж байгаа нь тухайн үед хийсэн судалгаагаар илэрхий болжээ.

Тэдний хурим сүй тавьснаас таван сарын дараа буюу 1981 оны долдугаар сарын 29-нд болов. Энэ өдрийг Британи даяар баярын өдөр мэт тэмдэглэлээ. Тэдний хуримын ёслолыг дэлхийн өнцөг булан бүрийн 750 сая хүн телевизээр хүлээн авч үзсэн байна. Гол ёслол болсон Гэгээн Полын сүмд Бэкингэмийн ордноос албан ёсны урилга хүлээн авсан 2000 зочин ирсэн байлаа. Хатан хаан болон түүний гэр бүлийнхэн найман сүйх тэргээр, морьтон цэргүүдээр хамгаалуулан сүмд хүрэлцэн иржээ. Хүндэт зочдын дунд АНУ-ын Ерөнхийлөгч Р.Рейганы гэргий Нэнси, Францын Ерөнхийлөгч, саарал хүрмээр гоёсон Франсуа Миттеран, гэргийн хамт байлаа. Чарльз, Диана хоёр бал сараараа “Британниа” хөлөг онгоцоор далайд аялахаар төлөвлөсөн болохыг энэ өдөр хэвлэлийнхэн олон түмэнд мэдээлсэн байна.



Сүмд болсон гэрлэх ёслолын дараа тэд сүйх тэргээр Бэкингэмийн ордонд хүрэлцэн ирж, тэнд цугларсан олон түмэнтэй тагтан дээрээс мэндчилж баяраа хуваалцжээ. Дараа нь үдийн зоог бариад, хатан хааны галт тэргээр Бродлэндын цайзад хүрэлцэн иржээ. Тэд энд хуримын анхны шөнөө үдсэн бөгөөд сонирхолтой нь тэдний буусан өрөөнд 1947 оны арваннэгдүгээр сард хатан хаан Элизабет, нөхөр Филиппийн хамт хуримын анхны шөнөө өнгөрөөж байсан аж.

Бродлэндэд хоёр өдөр, гурван шөнийг үдсэн залуу хос хоёр долоо хоногийн хугацаагаар Газар дундын тэнгист аялахаар “Британниа” хөлөг онгоцонд суусан байна. Гэвч энэ аялал Дианад олон таагүй зүйлийг мэдрүүлжээ.



Хунтайж Чарльз Дианагийн хоёр эгч Сара, Жейн болон дүү Чарльзийн хамт. 1985 оны тавдугаар сар.

Тэр эхлээд далайн давалгаанд шалаар нэг тарсан Камиллагийн зургийг Чарльзын өрөөнд үзэж, бас өдрийн тэмдэглэлийг нь уншжээ. Хэдэн өдрийн дараа үдийн зоог барьж байхдаа нөхрийнхөө чагтан товчин /запонки/ дээр “С” гэсэн хос үсэг томоор сийлсэн байхыг олж харжээ. Энэ үсгүүдийн учрыг ойлгож ядаад байх юм үгүй байлаа. Тэр бол Чарльз, Камилла хоёрын нэрний эхний үсэг болох нь /Англиар тэдний нэрийг Charles, Camilla гэж бичдэг/ тодорхой байв. Англидаа тэднийг эргэж ирэн иртэл нь Камиллагийн дурсгалууд Дианад ээлж дараалан ил болсоор л байлаа. Үүнд ихэд эмзэглэсэн Диана аяллын төгсгөл рүү дуугаа хураан бодлогошрох болсон байна. Балморал шилтгээнд ирээд түүний энэ байдал дээрдсэнгүй. Харин хэвлэлийнхний өмнө тэрбээр баяр баясгалантай, аз жаргалтай бүсгүйн дүрд чадварлагаар тоглож байлаа.


Гутгаар бүлэг



Хааны хүүхдүүд

Хунтайжийн хүүхдүүдийн эх болно гэж Диана мэдээж төсөөлж байгаагүй байх аа. Хатан хаан Элизабет ч хаан ширээ залгамжлах хүү төрөөсэй гэж хүсэж байлаа. Хааны удмын хүн бүхэн л ийм бодол тээдэг хойно доо. Залуухан, үзэсгэлэнтэй Диана хатан хааны гэр бүлийн бүрэлдэхүүнд орж ирснээр хатан хааны сэтгэл тайвширлаа. Үнэхээр ч Диана Уильям, Харри гэсэн хоёр сайхан хүү төрүүлсэн юм. Хатан хааны гэр бүлд энэ нь сайхан гэхэд ч багадмаар зөөлөн уур амьсгалыг авчирчээ. “Хоёр ач минь надад маш их аз жаргал авчирсан. Тэдний төлөө би өөрийн чадах бүхнээ хийхэд ямагт бэлэн байх болно. Тэднийг хайрлаж халамжлахад өөр хүний гар битгий оролцоосой гэж би хүсэж байна” гэж нэгэнтээ хатан хаан хэлсэн байдаг.

Галлын хунтайж гэрлэснээсээ хойш нэг их удалгүй буюу 1981 оны арваннэгдүгээр сарын 5-нд эхнэрээ жирэмсэн болсныг олон нийтэд зарлалаа. Хуучны уламжлал ёсоор Диана Бэкингэмийн ордонд бус Паддингтоны Гэгээн Марийн эмнэлгийн хяналтанд байх боллоо. Хатан хааны хувийн эмч нарын нэг, эх баригч, доктор Жорж Пинкер Дианаг халамжилж байлаа. Хатан хааны гэр бүлд халуун дулаан уур амьсгал зонхилж байсан болохоор хатагтай Диана 1982 оны зургадугаар сарын 21-ний 21 цаг 03 минутад элдэв хүндрэлгүй амаржлаа. Ийнхүү хунтайж 3.6 килограмм хүүтэй болов. Британичууд энэ мэдээг бас л баяр хөөрөөр дүүрэн хүлээж авлаа. Хэдэн долоо хоногийн дараа Уильям Артур Филипп Луйсыг загалмайлах ёслол Бэкингэмийн ордны хөгжмийн танхимд болов.



Ханхүү Харригийн аав, ээж болон ахынхаа хамт авахуулсан анхны албан ёсны зураг. 1984 оны аравдугаар сарын 14.

Галлын хунтайжийн анхны хүүг асралцах үүрэг хатагтай Барбара Барнест оногджээ. “Уильямыг асралцахад надад бэрхшээл байгаагүй. Учир нь аав, ээж хоёр нь хүүдээ маш их анхаарал тавьдаг байлаа. Тэд хүүгээ хооллож, усанд оруулж, хамтдаа салхинд гардаг байсан” гэж Барбара хожим нь дурсан өгүүлсэн байдаг юм.

1983 оноос эхлэн Диана гүнжийн нэр нөлөө олон улсын тавцанд өсч эхэллээ. Тиймээс тэрбээр гадаад орнуудад айлчлах нь олонтаа болов. Энэ үеэс асуудал үүсч эхэллээ. Австрали, Шинэ Зеландад хийсэн айлчлал буюу 70 мянган километр замыг туулсан урт аялалдаа тэр хүүгээ авч явжээ. Гэвч энэ үед нэг томоохон асуудлыг хамгаалалтын албаныхан хөндлөө. Хунтайж Чарльз, гүнж Диана нар нэг онгоцоор аялж, тэр битгий хэл хүүхдээ авч явж байгаа нь аюулгүй байдлын үүднээс болохгүй гэж тэд үзжээ. Гэвч үүнийг Диана тоомсорлосонгүй. Хэдхэн сарын дараа тэр Канадад айлчлахдаа хүүгээ аван нисчээ. “Хүү минь дэргэд байвал би илүү их аз жаргалтай байдаг” гэсэн үгээр тэр өөрийгөө зөвтгөлөө.

Энэ явдлаас хойш тун их удалгүй хунтайж Чарльз дахин нэг хүүгээ өлгийдөж авах ерөөлтэй байжээ. 1984 оны есдүгээр сарын 15-ны 16 цаг 20 минутад хоёр дахь хүү Хенри Чарльз Алберт Давид мэндлэв. Хожим нь энэ хүүг Харри гэдэг нэрээр дэлхий нийт мэдэх болсон билээ. Харриг 1984 оны арванхоёрдугаар сарын 21-нд Кантерверигийн хамба лам Роберт Рунси загалмайжээ. Олон түмний байнгын хараа хяналтын дор хүүхдүүдээ өсгөнө гэдэг хэнд ч амаргүй байх нь ойлгомжтой байлаа. Хөвгүүдээ бага, өсвөр насанд нь зөв

төлөвшүүлэх ёстой байв. Хааны ордны эртний уламжлалаар хүүхдүүд нь төлөв төвшин, эелдэг зөөлөн хүмүүс болон өсөх ёстой байлаа.

Бас Уильям, Харри хоёрын боловсролыг ганцхан асрагчид найдаж болохгүй нь тодорхой байв. Түүнээс гадна түргэн шаламгай асрагч Дианад хэрэгтэй байлаа. Диана бодож бодож өөрийнхөө эцгийнд ажиллаж байсан Тигги Леж-Буркыг сонгожээ. Асрагч Тигги хунтайж болон хүүхдүүдэд нь таалагдсан байна.

Диана хүүхдүүдийнхээ боловсрол олох сургуулийг өөрийн шалгуураар сонгохыг хүсч байлаа. Тэгэхдээ хөвгүүдэд нь аз жаргал өгч, эрх тэгш байдлыг хангаж чадах газрыг сонгоно гэж бодож байв. “Би эелдэг зөөлөн ээж байж, хөвгүүдээ халуун хайран дунд өсгөхийг хүсч байлаа. Хүүхдүүдтэйгээ байнга хамт хооллож, унтахад нь дэргэд нь байхыг хүсч байв. Энэ үнэхээр чухал” гэж Диана хэлсэн байдаг. Энэ үгийг тэр Чарльз, Диана хоёрын харилцаа хүйтэрч эхэлсэн үед хэлсэн байдаг юм.

1987 оны нэгдүгээр сарын сүүлээр Уильям, 1989 оны есдүгээр сарын дундуур Харри Кенсингтоны хороололд байх Ветерби сургуульд оров. Тэд Бэкингэмийн ордны ойролцоо байх Лудгровын коллежид орохоос татгалзсан аж. Хөвгүүдээ сургуульд орсноос хойш Диана тэдний аюулгүй байдалд санаа зовж, найз нөхдийнх нь хүрээлэлд ч хяналт тавихыг хүсч байв. “Би хөвгүүдээ хүүхдүүдтэй зодоон цохион хийх вий гэж үхтлээ айдаг байлаа” гэж Диана хожим дурссан нь бий.





Хатагтай Диана ханхүү Харригийн хамт дэлхийн хоёрдугаар дайн дууссаны 50 жилийн ойн баярын ажиллагаанд оролцож байгаа нь. 1995 оны наймдугаар сарын 19. Лондон



Диана том хүү Уильямын хамт Лондонгийн гудамжаар зугаалж яваа нь. 1997 оны зургадугаар сар.

Диана албан ёсны арга хэмжээнд оролцохдоо хөвгүүдээ гараас нь хөтлөн алхах юм уу,

тэдэнтэйгээ дотночлон ярилцаж суух нь олны нүдэнд содон тусдаг байв. Тэр бас сургууль дээр нь зохиогдсон баярт оролцож, тэдэнтэйгээ хувцас авахаар “Харродс” их дэлгүүрийг зорьж, “Макдональдс”-т үдийн хоол идэж, кино үзэх дуртай байжээ. Мөн хүүхдүүдээ газар үзүүлж, нүд тайлуулахаар Испани ч юм уу, Флоридагийн Диснейлэндийг зорих нь олонтаа.

Харин Чарльзын хувьд тийм ч сайн аав байсангүй. Магадгүй хүүхдүүдээ хайрлах, халамжлах Дианагийн “сүүдэр”-т дарагддаг байсан байж болох юм. Зөвхөн нэг жишээ дурдахад, 1991 онд том хүүгээ гольф тоглож байгаад духны ясаа цөмлөчихөөд эмнэлэгт хэвтэж байхад Галлын хунтайж хэвнэг дуурь үзсэн шиг явж байсан гэдэг. Харин Диана хүүхдийнхээ дэргэд, эмнэлгийн өрөөнд хэдэн өдрийг үджээ.

Мөн онд Диана, Чарльз нар хамтдаа хоёр хүүхдээ дагуулан Канадад албан ёсны айлчлал хийжээ. Хоёр хүүг нь аюулгүй байдлын үүднээс тусад нь авч явсан байна. Уильям, Харри хоёр “Британниа” хөлөг онгоц зогсох Торонтогийн боомт дээр эцэг, эхийгээ тэвчээртэй хүлээж байлаа. 24 цагийн дараа тэд ирсэн бөгөөд Диана албан ёсны угталт, гэрэл зурагчид, телевизийн зураглаачид, цугласан олныг огт хайхралгүй, нүүрэндээ инээмсэглэл тодруулан, хоёр гараа дэлгэн хүүхдүүд рүүгээ гүйжээ. Эхийн хайр гэж ийм аугаа буюу.

Диана том хүү Уильямтайгаа насанд хүрсэн хүн шиг илэн далангүй ярьж хөөрдөг байв. Тиймээс ч тэр “Уильям бол надаас хэзээ ч урвахгүй ганц эр хүн” гэж хэлсэн биз ээ. Заримдаа ямар нэг юмнаас болж ээжийнхээ уйлахыг сонсоод тайтгаруулахаар Уильям өрөөнд нь гүйж ордог байв.

“Би хүүхдүүдийнхээ төлөө, тэдний сайн сайхан, аз жаргалтай ирээдүйн төлөө бүх л талбарт тэмцэх болно. Миний хүүхдүүд хүмүүсийн зүрх сэтгэл, хүсэл мөрөөдөл, итгэл найдварыг ойлгодог эрчүүд болж өсөөсэй гэж хүсч байна” хэмээн Диана бас нэгэнтээ хэлсэн байдаг юм. Түүний амьдралын гол зорилго энэ байсан нь гарцаагүй билээ.

Дөтгөөр бүлэг



Дианаг бишрэх үзэл

Хунтайж Чарльзтай гэрлэх болсон тухай албан ёсоор зарласан өдрөөс эхлэн Диана жинхэнэ од болсон юм. Өөрөөр хэлбэл, тэр хэвлэлийнхний “овоо хараандаа” авсан ганц хүн нь болж хувирсан билээ. Энэ үеэс л “Дианаг бишрэх үзэл” эхэлсэн юм. Түүнээс өмнө Дианаг хилийн чанадад огтхон ч мэддэггүй байжээ. Тиймээс ч тэр АНУ-д ч, Австрали, Канад, Хөгшин Европт ч чөлөөтэй алхаж, дэлгүүр захаар хэсч, худалдаа наймаа хийдэг байв. Гэхдээ л түүний ялдам инээмсэглэл олон хүний хайрыг татдаг байжээ.

Гэвч тун удалгүй Дианаг бишрэх үзэл газар авч эхэллээ. Түүнтэй ижил төрхтэй болох гэсэн, үгүй ядахдаа л үсээ адилхан засуулсан бүсгүйчүүд олширлоо. Дианагийн өмссөн хувцас тэр даруйдаа л моод болж байв. Хурим болсноос хойш хэдхэн цагийн дараа Дианагийн өмссөнтэй төстэй хуримын даашинз худалдаанд гарч эхэлсэн байлаа. Загвар зохион бүтээгч Эммануэлийн урласан ийм даашинз Дебенхэмийн их дэлгүүрт хэдэн зуун фунт стерлингээр дорхноо борлогдож байв.

Хэдэн жилийн дараа гэхэд энэ үзэл бүр ч гаарлаа. Нэгэнтээ Францын тэргүүн хатагтай Бернадет Ширак Дианад “Хатагтай Диор” сүрчигний дээжээс бэлэглэжээ. Үүнийг сонссон Дианаг бишрэгчид адилхан сүрчиг хэрэглэхээр гоо сайхны дэлгүүрүүдийг зорьлоо. Зургаахан сарын дотор ийм сүрчиг 200 мянган ширхэг зарагдсан гээд бод доо.

Маш түргэн хугацаанд Диана дэлхийн хэмжээний од боллоо. Тэр албан ёсны хувцасны моод дэлгэрүүлэгч болж хувирлаа. Хэрхэн биеэ авч явах урлагийн жинхэнэ амьд үлгэр жишээ нь Диана болов. Урьд өмнө нь хааны гэр бүлийн ямар ч хүн ийм өндөр амжилтанд хүрч байгаагүй юм. Нэг ёсондоо Диана Британийн хааны ордныхны нэрийн хуудас болж байлаа.



Чарльз, Диана хоёр XIX зууны сүүл үеийн Канадын үндэсний хувцсаар гоёод байгаа нь. 1983 оны зургадугаар сард Канадад хийсэн албан ёсны айлчлалын үеэр энэ зургийг татуулжээ.



Хатагтай Дианад Японы үндэсний хувцас кимоно гайхалтай зохицжээ. 1986 оны тавдугаар сард Японд албан ёсны айлчлал хийхдээ энэ зургийг татуулжээ.

Байнга олны анхааралд байх болсон тул Диана өдөр ирэх тутам өөрчлөгдөж байв. Энэ

өөрчлөлтийг гурван хэсэгт хувааж үзсэн сэтгүүлч ч байдаг. Нэгдэх нь дэврүүн сайхан сэтгэлтэй, ялимгүй бүрэг Диана. Энд сүй тавьснаас эхлэн Харриг төрүүлэх хүртэлх үе хамаарна. Хоёр дахь нь дэлхийд од болсон Диана. Британийн өнгө төрх болсон түүний гоо үзэсгэлэн дэлхийн олон сая хүний хайр бахархлыг татаж байлаа. Гурав дахь нь зүрх сэтгэл нь шархалсан Диана. Гэхдээ тэр гадна өнгөндөө үзэсгэлэн гоо, эелдэг зөөлөн бүсгүй хэвээр байж, сэтгэлийн зовлон шаналлаа хэнд ч харуулдаггүй байсан юм.

“Диана хааны гэр бүлийн түүхэнд байгаагүй шинэ үзэгдэл болсон. Олон жилийн турш хэвшил болсон дадал заншлыг тэр зад татаж хаясан юм. Түүний дүр төрх, хувцаслалт, биеэ авч яваа байдал гэрэл зурагчдыг ажилтай болгож, бас тэдний нүдэн дээр Диана огт өөр хүн болон өөрчлөгдөж байлаа” гэж сэтгүүлч Хюго Викер хэлсэн байдаг. Гэрлэснээсээ хойш төдий л удаагүй байхдаа тэд Австрали, Шинэ Зеландад албан ёсны айлчлал хийсэн юм. Энэ үеэс л Диана олон түмний хүндлэл, бишрэл гэж ямар айхтар зүйл байдгийг ойлгож авчээ. Бүрэг даруу жаахан бүсгүй хувцаслалт, биеэ авч явах байдалдаа онцгой анхаарах ёстойгоо ойлгосон байна. Азтай нь бурхан түүнд гоо үзэсгэлэнг харамгүй заяасан байлаа. Моодны алдартай сэтгүүл “Vogue”-ийн захирал Анн Харви “Дианагийн урт сайхан хөлийг бахархахгүй байхын аргагүй” хэмээн хэлсэн байдаг нь нэгийг өгүүлнэ.



Үзэсгэлэнт Дианагийн өвөрмөц дүр төрхүүд

Түүний өөрчлөлт өөр юугаар илэрч байв аа? Үүнд үсний засалт гэсэн товчхон хариулт өгч болно. Гэрлэснийхээ эхний жилүүдэд тэр өөрийн үсчин Кевин Шеналигийн хэлснээр л үсээ засуулчихдаг байв. Хожим нь Кевин түүний тухай “Дианагийн гэрэл гэгээ” гэсэн ном бичсэн юм. Тэр үед Диана үсээ дух руугаа унжуулж, богиносгон тайрсан хэлбэрээр засуулдаг байжээ. Харин ханхүү Харриг төрүүлснийхээ дараа үсний засалтаа өөрчилжээ. Тэрбээр Ричард Далтоны зөвлөснөөр үсээ ардаа овоолсон маягаар засах болжээ. Ийм засалттай авахуулсан зураг нь дэлхий даяар тархсан юм.

Диана хувцаслалтандаа гойд анхаарч байсны нэг илэрхийлэл нь 1991 онд хийсэн нэгэн тооцоо юм. Кенсингтоны ордонд байх түүний хувцасны шүүгээнд орой үдэш өмсөх зориулалттай 95 хувцас, гоёлын 176 даашинз, 178 хүрэм, 54 пальто, 141 малгай, 350 хос гутал, 200 гар цүнх байсан гэдэг. Сэтгүүлч Маргарет Холдерийн тооцоогоор бол Диана 10 жилийн дотор 11 сая франкыг гоо сайхны бүтээгдэхүүн худалдан авахад зарцуулсан байна. Үнэхээр ч энэ цаг үед Диана Их Британийн эмэгтэйчүүдийн хувцаслалтын моодыг үргэлж шинэчилж байсан гэхэд хилс болохгүй. Тэр нэртэй загвар зохион бүтээгчидтэй хамтран энэ бүхнийг хийж байлаа.

Аль нэг улсад албан ёсны айлчлал хийхээр явах үедээ Диана моодны нэг загварыг бий болгодог байжээ. Тэр загвар зохион бүтээгч Катерин Уолкертэй хамтран ажиллах их дуртай байж. Бас Брус Олдфиелд, Дэвид Сассун, Мюрри Арбейд, Виктор Эделстейн нар Дианаг домог болгоход туслаж байлаа. Урт, бариу торгон даашинз, өнгө нь нэн зохицсон хилэн хослолоор гоёсон Диана олон оронд зочилж, түмний нүдийг бүлтийлгэж байв. Диана 1997 оны зургадугаар сард эдгээр хувцасныхаа заримыг Нью-Йоркийн “Кристи” дуудлага худалдаагаар үнэ хаялцуулан худалдсан юм. Үүгээрээ тэр 18 сая франк цуглуулж чадсан бөгөөд тэр мөнгөө өмөн үү, ДОХ-оор өвчилсөн хүүхдүүдийн эмчилгээнд зориулан “Роял Марсден”-ны эмнэлэгт хандивласан байна.





Үзэсгэлэнт Дианагийн өвөрмөц дүр төрхүүд

15 жил хааны ордонд амьдарсан Диана 1996 онд хунтайжаас албан ёсоор салж чөлөөт эмэгтэй боллоо. Тэр заавал албан ёсны хувцас өмсөх шаардлагагүй болов. Ингээд Диана нэрд гарсан загвар зохион бүтээгч Версаче, Диор, Армани, Гучигийн чөлөөт хувцасыг илүүд үзэх болжээ. Тэр иймэрхүү чөлөөт хувцасаар гоён Египет, Пакистанд зочилж, 1996 онд Нью-Йоркод болсон Диорын 50 жилийн ойн баярт оролцсон юм.

Энгийн чөлөөтэй хувцаслах болсноор тэр улам ч үзэсгэлэнтэй харагдах болжээ. “Дианагийн муухай, зохицоогүй хувцастай зургийг дарна гэдэг бүтэшгүй юм байна гэж гэрэл зурагчид ярьдаг байсан” гэж “International Herald Tribune” сонины сэтгүүлч Сузи Мэнк нэгэнтээ хэлсэн байдаг. Диана хувцасаа сайхан өмсөхөөс гадна гоо сайхандаа онцгой анхаардаг байжээ. Тэр биеийн жингээ тогтмол нэг хэмжээнд барьж байхын тулд усанд сэлэлтээр байнга хичээллэдэг байлаа. Үзэсгэлэнт Диана олны хайрыг өдөр ирэх тусам татах болсон үеэсээ л дэлхийн шоу бизнес, моодны ертөнцийн олон ододтой найзалж нөхөрлөх болжээ. Дианаг од болоход тэдний нөлөө асар их байсан юм. Тиймээс ч тэр хүмүүсийн сэтгэлд одоо хүртэл мөнх байгаа юм. “Ард түмний гүнж” хэмээх алдрыг тэр зүгээр ч нэг хүртээгүй юм. Хааны ордны хатуу ёс заншилыг сөрөн гарч чадсан цорын ганц хүн бол Диана. Тиймээс Дианаг шүтэх үзэл одоо ч буураагүй байна.

Тавдугаар бүлэг



Зөрчил

Эвдрэлийн анхны үүд 1987 онд тавигджээ. Португальд хийсэн албан ёсны айлчлалын үеэр Чарльз, Диана хоёр тус тусдаа өрөө захиалсан байлаа. Гэвч тэд өнгөн дээрээ эвтэй найртай байхыг хичээж, өөрсдийнхөө харилцаанд үүссэн хүйтэн хөндий уур амьсгалыг далдлахыг оролдож байв. Гэвч үнэн хэрэгтээ бол Кенсингтоны ордны дээр удаан хугацааны турш үргэлжлэх анхны хар үүл хуралдаж эхэлсэн байлаа. Улмаар Диана, Чарльз хоёрын харилцаа улам хүйтэрч, нэг нь Хиггровт, нөгөө нь Кенсингтоны ордонд амьдрах болжээ. Тэд албан ёсны арга хэмжээнд оролцохоосоо бусад үед аль болох уулзалдахгүй байхыг хичээх болсон байна. Гэвч тэд нэг их удалгүй харилцаагаа сэргээжээ. Дахин тэд хамтдаа байх болж “зууны гэрлэлтийн”-хээ долоо дахь зуныг цуг үдэв. Тэдний энэ эвлэрэл асар их үнэ цэнэтэй байлаа.

Гэвч 1988 оны аравдугаар сард тэдний гэрт нэгэн асуудал үүслээ. Хэдийгээр тэд дахин тусдаа амьдраагүй ч өөр хоорондоо маргаан өрнүүлэх нь олон байв. Тэр өдөр Диана рок, попын ододтой үдийн зоог барьж, буяны ажилд гар бие оролцохыг хүсчээ. Харин Чарльз Шекспирийн уран бүтээлээр хийх эрдэм шинжилгээний маргаан мэтгэлцээнд оролцох бодолтой байв. Үүнээс болж санал зөрөлдсөн нь нилээд ноцтой үр дагавар авчрав.

Маргааш нь хааны гэр бүлийн ойрын хамаатны хуриманд оролцоод буцахдаа тэд зэрэгцэн суусангүй. Үүнээс хэд хоногийн дараа тэд Германд айлчилжээ. Хэвлэлийнхэн мэдээж тэр хоёроос хараа салгасангүй. Берлинд Чарльз, Диана хоёр аз жаргалтай хосуудын дүр эсгэж, жинхэнэ эмгэнэлт инээдмийн жүжиг тоглолоо. Тэд инээлдэж, ихэд элэгсэгээр ярилцаж, бие биенээ үнсэж байв. Тэр битгий хэл Чарльз Дианад “Чи минь армийн хурандаа шиг л гоё харагдаж, гялалзаж байна” хэмээн хэлсэн гэж сэтгүүлчид бичиж байлаа. Цэнгэлдэх хүрээлэнд очихдоо ч аз жаргалтай хосуудын дүр эсгэв. Тэд тэнд цугласан олон түмэнтэй элэгсэгээр мэндэлж, гараараа үнсэлт илгээж байлаа. Үүнээс хойш нэг их удалгүй тэр хоёр тусдаа байх боллоо. Чарльз Камилла дээрээ эргэн очжээ. Тэр нууц амрагтаа зориулж Хиггровт жижгэвтэр байшин барьж өгсөн байлаа. Харин Диана багш Дэвид Хэвитийн туслалцаатайгаар морь унах дасгал хийж, элдэв таагүй зүйлээ мартахыг хичээж байв.

Дианагийн үлгэрийн гүнж шиг амьдрал ийнхүү ээдрээтэй болж эхэллээ. Хунтайж Чарльз

түүнээс 12 насаар ах байсан нь ч тэдний харилцаанд нөлөөлж байв. Тэдний үзэл бодол өдөр ирэх тусам зөрчилдөж байлаа. Гэвч Диана салах шийдвэрийг юуны түрүүнд гаргаж болохгүй байв. Учир нь салалт гэдэг хүүхдүүдэд ямар хүндээр тусдгийг тэр багадаа өөрийн биеэр мэдэрсэн байлаа. Бас хааны ордны бичигдээгүй хуулиар хаан ширээ залгамжлах хүн хэзээ ч гэр бүлээ цуцлуулж болохгүй.



Хатагтай Диана Ливерпүүлийн хойд хэсэгт орших Сүтпортын эмнэлэгтэй танилцаад нулимс дуслуулан гарч ирсэн агшин.

1992 оны зургадугаар сар.



Хунтайж Чарльзийн үнсэлтээс гүнж Дианагийн аятайхан бултаж буй агишин. 1992 оны хоёрдугаар сард Шинэ Делид албан ёсны айлчлал хийх үеэр.

Диана Английн ирээдүйн хаантай гэрлэхээр зоримог шийдвэр гаргаж байхдаа араасаа ямар аюул, үл ойлгогдох төвөгтэй байдал дагуулахыг урьдчилан тааварлаагүй юм. Тэгэх ч арга байгаагүй. “Эхлээд би Чарльзыг хайрладаг, тэр хайраа түүнтэй хуваалцахыг хүсдэг байсан. Аажимдаа миний хайр бөхсөн. Үүнд олон зүйл нөлөөлсөн” гэж Диана хожим нь дурссан байдаг. Ийнхүү өдөр ирэх тутам Дианагийн итгэл найдвар, мөрөөдөл хүсэл унтарч байлаа. Чарльзад өөр нэгэн эмэгтэй байдгийг мэдсэнээр түүний зүрх бүр ч ихээр шархалжээ.

Галлын гүнж, ирээдүйн хааны хатны суудлаас татгалзах нь түүнд юу ч биш байлаа. Хэдэн зуун мянган залуухан бүсгүйчүүд ямар ч сайхан амьдралыг гүнжийн алдраар солиход бэлэн байсан цаг үе шүү дээ. Хорьхон насандаа хатан хааны гэр бүлийн гишүүн болсон Дианад ордны хэтэрхий хатуу журам дэглэм, ёс заншил огт таалагддаггүй байв. Тиймээс тэр энэ бүхэнд баригдахгүй, өөрийгөө чөлөөтэй байлгахыг ихэд эрмэлздэг байсан юм.

Чарльз уран барилга, дуурь, сонгодог хөгжим, полод дуртай байв. Бороо орж байхад соман загас барих, ой шугуйгаар удтал зугаалах, найзуудтайгаа үдийн зоог барин ярьж суух нь ч түүний дуртай ажлын нэг. Харин Диана үсчинд очиж, дэлгүүр хэсч, хувцас худалдан авч, ресторанд найзуудтайгаа өглөөний зоог барьж, рок концерт үзэх дуртай байв. Тэр бас оройг найзуудтайгаа бүжиглэж өнгөрөөхийг илүүд үзнэ. Энэ байдал ч тэдний харилцаанд нөлөөлж байсан нь дамжиггүй.



1992 оны зургадугаар сард Андреу Мортоны “Диана. Түүний үнэн түүх” ном хэвлэгдэн гарч дэлхий даяар шуугиан дэгдээлээ.



Диана, Чарльз хоёрын зөрчлийн гол эх үндсийг тавьсан хатагтай Камилла Паркер Боулз.

Хэдийгээр Чарльз 1981-1986 оны хооронд ганц ч удаа уулзаагүй ч гэсэн Камилла Паркер Боулзтай харилцаагаа дахин сэргээсэн нь бүр ч нэрмээс боллоо. Хаана л бол хаана Камиллагийн тухай яриа өрнөж, сонин хэвлэл дуугаа нэгтгэн шуугиж, Дианаг байх суух

газаргүй болгож байв. Зарим үед түүнд амиа хорлох санаа ч төрж байсан гэдэг. “Энэ гэр бүлд өдөр ирэх тутам сэтгэл санаагаар унаж, нус нулимсандаа хутгалдаж байгаа хүн ганц би л байлаа. Үнэндээ би тэвчээрээ барж байсан. Бид хоёрын хооронд яг юу болоод байгааг хэн ч сонсохыг хүсэхгүй байв. Сэтгэл санаагаар унаснаас болсон уу, бие минь тавгүйрхэж эхэллээ. Өдөрт дөрвөөс таван удаа гэдэс минь дүүрч, улмаар үе үе бөөлжис хүрдэг болов. Би элдэв юм бодолгүй өвчнийхээ эсрэг тэмцэх хэрэгтэй байв. Бидний хооронд болж байгаа зөрчлийг хэн ч хараагүй, сонсоогүй болохоор ард түмэн маань хэвлэлийнхний элдэв хачиртай мэдээллээр л дүгнэлт хийж байлаа. Намайг өвдсөнийг ч сайн мэдээгүй байх. Миний энэ өвчин их удаж байж, бараг дөрвөн жилийн дараа бүрэн эдгэрсэн шүү” гэж олон жилийн хойно Диана дурсан өгүүлсэн байдаг.

1986 онд өөрийн нөхрөө Камиллатай харилцаагаа дахин сэргээж, тэдний хайр дурлал эргэн асч эхэлснийг Диана сайн ойлгож байлаа. “Өөр хүнд сэтгэл алдарсан эр нөхөртэй байснаас байгаагүй нь дээр. Тийм үед сэтгэл санаа хоосрох шиг болдог юм. Гурван хүн гэрлэж болдоггүйгээс хойш яах билээ” гэж Диана бас дурссан байдаг.

Энэ хүнд байдлаас гарах зам бол олон түмэнтэй ойрхон харилцаатай байх гэж Диана бодож байлаа. Тиймээс тэр урлагийн нэгэн од шиг ард олны хайрыг татахаар шийджээ. Удалгүй тэр үнэхээр энэрэн нигүүлсэхүйн үзэлтэй үзэсгэлэн гоо гүнж гэдгээ харуулсан билээ. Энэ үед Чарльз Хиггровт байх байрандаа байнга суух болжээ. Түүний байрнаас хоёрхон алхмын зайд нууц амраг Камилла Паркер Боулз нь амьдарч байлаа. Тэд эргэж эвлэх гэж нэлээд хүч заржээ. Чарльз, Камилла хоёрын маргалдах чимээ үе үе дуулддаг байсан гэдэг.


Хунтайж, гүнж хоёрын харилцаанд цав гарсан, энэ нь нилээд ноцтой гэдгийг 1990 оны арваннэгдүгээр сард л Английн хэвлэлүүд анх мэдээлж эхэлсэн юм. Сүүлийн зургаан сард тэд гуравхан удаа л албан ёсны арга хэмжээнд хамтдаа оролцсон нь хэвлэлийнхний анхаарлыг ихэд татжээ.

Галлын хунтайжийн гэр бүлийнхэн албан ёсны сүүлчийн гэрэл зургаа Канадад айлчлал хийх үеэрээ авахуулжээ. Тэдний хооронд ноцтой маргаан дэгдсэнийг мэдсэн британчууд Чарльз, Диана хоёрын хувийн амьдралыг бүр ч шимтэн сонирхох болжээ. Ингэж байтал 1991 он гарав. Диана 30 нас хүрлээ. Бас гэрлэснээсээ хойш 10 жилийг нэгэнт ардаа үджээ. Гүнжийн 30 насны төрсөн өдөрт зориулж Чарльз үдэшлэг зохиохоор шийджээ. Энэ үед Персийн буланд дайн эхлээд байлаа. Үүнтэй адил Чарльз, Диана хоёрын харилцаа бүр ч муудаад байв.

Чарльз, Диана хоёр найз нарынхаа тэр хоёрын харилцааг илтэд сонжсон харцны дор нэгэн оройг үдсэн байна. Гэрлэснийх нь 10 жилийн ойн өдрүүд ард үлдсэнээс хойш тэдний харилцаа улам бүр муудсаар байлаа. Үүний нэг илрэл нь 1992 оны хоёрдугаар сард Энэтхэгт албан ёсны айлчлал хийх үеэр Таж Махалын өмнө Дианагийн гав ганцаараа авахуулсан сэтгэл уярам зураг болсон юм.

Үүнээс хойш нэн их удалгүй хатан хааны гэр бүлийнхэнд бөмбөг тэсэлсэнтэй дүйхүйц нэгэн явдал тохиолоо. Энэ бол 1992 оны зургадугаар сард хэвлэлтээс гарсан Андреу Мортонь “Диана. Түүний үнэн түүх” гэсэн ном байв. Энэ номонд Дианагийн амиа хорлох гэсэн оролдлого, сэтгэл гутрал гээд олон нууцыг дэлгэсэн билээ. Үүний дараа хунтайж Чарльз, гүнж Диана нар хамтдаа Газар дундын тэнгист аялсан ч тэдний харилцаа сайжирсангүй.

Иймээс сүүлд нь “Аймшигт” хэмээн нэрлэх болсон 1992 оны сүүлээр хатан хаан Элизабет II хосуудыг албан ёсоор салж байгааг мэдээлж, энэ бүхэнд цэг тавихаар шийдлээ.



Хатагтай Дианагийн Таж Махалын өмнө гав ганцаараа татуулсан энэ зураг түүний цөхрөл ганцаардлын тод жишээ болсон юм. 1992 оны хоёрдугаар сар. Энэтхэг.

Тэдний салж байгааг 1992 оны арванхоёрдугаар сарын 9-ний лхагва гаригийн 15 цаг 30 минутад Их Британийн Ерөнхий сайд Жон Мэйжор албан ёсоор зарлажээ. “Бэкингэмийн ордноос маш харамсалтай мэдээ бидэнд ирлээ. Галлын хунтайж, гүнж нар гэр бүлээ цуцлуулах шийдвэр гаргажээ. Энэ шийдвэрийг тэд харилцан сайтар ойлголцсоны үндсэн дээр гаргасан байна. Хүүхдүүдийнхээ боловсролд тэд адилхан анхаарал тавина. Мөн тэд гэр бүлийн хүрээний уулзалт, үндэсний баяр, тэмдэглэлт ёслолд хамтдаа оролцож байх болно. Ийм явдал болсонд хатан хаан болон Эдинбургийн бэйс нар гүн харамсал илэрхийлж байна” хэмээн Ерөнхий сайд хэлжээ.

Ийнхүү Чарльз, Диана хоёр гэр бүлийн байнгын хэрүүл маргаанаасаа салах эхлэлээ тавилаа. Гэхдээ албан ёсоор гэр бүлээ цуцлуулах бичиг баримт бэлэн болох хүртэл дөрвөн жил шаардагдана гэж хэн нь ч бодоогүй биз ээ. Мэдээж хэрэг, Диана нэг ёсондоо сэтгэлийн зовлонгоосоо ийн ангижирсан юм.

Бас дотрын өвчнөө сайтар эмчлэх, зөвхөн өөрийн хувь заяаныхаа төлөө ямар нэг хүлээсэнд баригдалгүй тэмцэх бүрэн боломж түүний өмнө нээгдсэн билээ.

Зургадугаар бүлэг



Зүрх сэтгэлийн Хатан хаан

1997 оны наймдугаар сард Диана, Доди Аль Файедын хамт сүүлчийнхээ буяны үйлсэд оролцсон юм. Тэд Боснид гурав хоногийн хугацаагаар очиж, хуучин Югославын дайны үед газрын минанд өртөж шархадсан хүмүүстэй уулзаж, тэдэнд сэтгэлийн дэм өгчээ. “Үхлийн ирмэг дээр байгаа гэм зэмгүй хүмүүст бага ч болов урам зориг хайрлахыг би үүргээ гэж үзсэн. Үе мөчөө тайруулсан, үлдэх амьдралдаа итгэл алдарсан дэндүү өрөвдмөөр тэднийг дэлхий ертөнц дээр ойлгодог хүн тийм ч олон биш. Тиймээс би тэдний зовлон шаналлыг бүх дэлхийн хүн ардуудад ойлгуулахыг хүссэн юм” гэж Диана Улаан загалмай нийгэмлэгийн элчээр Анголд очихдоо хэлж байсан түүхтэй. Үүнийгээ ч тэр хангалттай биелүүлсэн. Гэвч түүний энэ үйл ажиллагааг Английн хуучинсаг үзэлтэй улстөрчид эсэргүүцэж, улстөржүүлж байсан түүх ч бий. “Би улстөрч биш. Тийм болохоор миний хийсэн үйлдлийг улс төрийн өнцгөөс огт харах хэрэггүй. Хүмүүнлэг нинжин сэтгэл улс төртэй авцалддаггүй юм” гэж Диана хариуг нь тэр дор нь барьж байсан билээ.

Лахорт байх “Шокат Канум” эмнэлэгт Дианаг зочлоход ч Английн хэвлэлүүд түүнийг буруутгаж байсан. Пакистаны крикетийн аварга Имран Каны үүсгэн байгуулсан эмнэлэгт зочлохдоо хувийн сонирхлоо илүүд үзлээ, Беназир Бхуттогийн эсрэг үзэлтэй хүнийг дэмжлээ гэж шуугиж байв. Тэрхүү Имран Кан бол Дианагийн дотны найз нарын нэг Жесика Голдсмиттэй ханилан суусан байлаа. “Шүүмжлэл надад тус болж, би тэр бүхнээс суралцаж байв. Би хэвлэлийнхний болон улстөрчдийн ямар ч шүүмжлэлд эмзэглэж байгаагүй. Харин өөрийнхөө сонгосон замаар тууштай замнах, илүү эрч хүчтэй ажиллахад минь шүүмжлэл тус болж байсан. Нийгмийн эмзэг давхрагын хүмүүстэй уулзаж, тэдэнд туслахыг оролдох нь харин ч надад аз жаргал авчирч байсан. Миний амьдралын гол зорилго, гол ажил бол хүмүүнлэгийн үйлс байсаар байх болно. Энэ миний хувь тавилан” гэж Диана нэгэнтээ хэлж байжээ.



Хатагтай Диана Лондонд байх Хинди шашны сүмд зочилж байгаа нь. 1997 оны зургадугаар сар.



Хатагтай Диана Тереза эхийн хамт Нью-Йоркийн Бронкс дүүрэгт зочиллоо. 1997 оны наймдугаар сарын 18.

Дианагийн хүмүүнлэгийн үйлс 1987 онд эхэлсэн юм. Тэрбээр Лондонд нээгдсэн ДОХ өвчтэй хүмүүст халамж, дэмжлэг үзүүлэх анхны холбооны нээлтэд оролцжээ. Учир нь энэ үед түүний дотны найз Адриан Вард-Жексон ДОХ-ын нянгаар өвчилсөн нь тодорхой болоод байсан юм.

“Ийнхүү хүмүүнлэгийн үйлсэд Диана оролцож эхэлсэн нь энэрэл нигүүсэл, хайр дурлал, ухаарал гэмшлийг дэлхий ертөнцийн олон хүнд ойлгуулахад маш хүчтэй түлхэц болсон юм” гэж Вашингтонд байрладаг Гэр бүл, хүүхэд залуусын төлөөх үндэсний төвийг үүсгэн байгуулагч Давид Харви онцлон дурдсан байдаг билээ. Заримдаа Диана хэвлэлийнхнээс зугатаж энэрэл хайр хүссэн хүмүүстэй уулздаг байжээ. Энэ нь Диана хүмүүнлэгийн үйлсэд чин зүрхнийхээ дуудлагаар оролцож байсан болохоос хэвлэл сонингоор гарч нэр хүндээ өсгөх зорилгогүй байсны бүрэн нотолгоо болдог юм. “1995 оны арванхоёрдугаар сард Диана хэвлэлийнхнээс зугатан шөнө дөлөөр эмнэлэгт очиж үхлийн ирмэг дээр байгаа өвчтөнүүдтэй уулзаж, тэдэнд сэтгэлийн тэнхээ, итгэл найдвар хайрлахыг хичээж байсан” гэж Английн томоохон сонинуудад мэдээлсэн нь бий.

“Олон зуун өвчтэй хүмүүст би амьдралд итгэх итгэл хайрлахыг хичээж байсан. Эмнэлэгт, асрамжийн газарт, тэр ч бүү хэл хагалгааны өрөөнд ч би тэдэнтэй уулзаж байлаа. Би тэдэнтэй гар барьж, ярилцаж, та бүхэнд туслах хүн энэ хорвоод маш олон бий гэж хэлдэг байв” хэмээн Диана дурссан байдаг. Гэр бүлд нь үүссэн үл ойлголцол, нөхөртөө итгэх итгэл алдарснаас бусдад, тэр тусмаа өвчин зовлон, гай гамшигт өртсөн хүмүүст илүү их анхаарал тавих боломж Дианад гарсан юм. Тиймээс тэр 1993 оны арванхоёрдугаар сард хүмүүнлэгийн үйлсэд идэвхийлэн оролцож байхаа илэрхийлсэн бол 1995 оны сүүлээр ВВС-гийн “Panorama” нэвтрүүлэгт оролцохдоо “Хүмүүсийн зүрх сэтгэлийн хатан хаан” байхын төлөө бүх л хүч чадлаа зориулахаа мэдэгдсэн билээ. Халдварт хүнд өвчинд нэрвэгдсэн хүмүүс, өндөр настан, орох оронгүй болон өмөн үү өвчтэй хүүхдүүд гээд түүний анхаарал тавих хүрээ маш өргөн байлаа.



*Хатагтай Диана газрын минанд өртөж тахир дутуу болсон хүүхдүүдтэй уулзаж байгаа нь.
Ангол*

1996 оны дөрөвдүгээр сард Диана Камеруны долоон настай хүүд зүрхний маш хүнд мэс засал хийхэд дэргэд нь байлцсан юм. Хагалгаа бүтэн дөрвөн цаг үргэлжилсэн бөгөөд энэ тухай

телевизийн бүх сувгаар мэдээлж байсан билээ. Тэрбээр олон удаа буяны ажил зохиож, хүмүүнлэгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудтай хамтран ажиллаж байв. Өөрийн ажлын хүрээгээ тэлэхийн тулд алдар цуутай олон хүнтэй Диана холбоо тогтоож, тэдний туслалцааг авч байсан юм. Үүний нэг жишээ бол Тереза эхтэй тогтоосон найрсаг харилцаа байлаа. Тэд маш дотно харилцаатай байсан бөгөөд 1997 оны зургадугаар сарын дундуур Диана Тереза эхийн хамт АНУ-д айлчилсан юм. Тэд хамтдаа Нью-Йоркын захын ядуу дүүрэгт очиж хүмүүстэй уулзаж ярилцаж байсан түүхтэй.

Дианаг оршуулах ёслолд хүмүүнлэгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 106 байгууллагын 500 гаруй төлөөлөгч оролцсон нь түүний ямар өргөн хүрээтэй ажиллаж байсны нэг илэрхийлэл болдог. Үнэхээр ч тэр үхэн үхтэлээ “Хүмүүсийн зүрх сэтгэлийн хатан хаан” байхын тулд олон сайхан буянт үйлс бүтээсэн. Тэгээд ч Диана зорилгодоо хүрч чадсан юм.

Долдугаар бүлэг



Эрх чөлөөт бүсгүй


Галлын гүнж, ирээдүйн хааны эх яагаад эрх чөлөөт замыг сонгов оо гэдэг нь олон хүний анхаарлыг үнэхээр татаж байлаа. Чарльз, Диана хоёрыг албан ёсоор салж байгааг Ерөнхий сайд мэдээлсний маргаашнаас эхлэн хэвлэлийнхний дайралт эхэллээ. Энэ нь Дианагийн хувьд үнэхээр аймшиг байв. Уильям, Харри хоёр анх удаа аав болон Виндзорын ордныхны хамт шинэ жилээ Сандринхэмийн шилтгээнд тэмдэглэлээ. Өөрөөр хэлбэл, ээж нь тэр баярт оролцсонгүй. Үүнээс хэдхэн хоногийн дараа Диана хэвлэлийнхнээс жаахан ч болов зугатаахын түүс болж хүүхдүүдээ дагуулан Карибын тэнгисийг зорьж, Невис арал дээр амрахаар явжээ.



Хатагтай Диана цэргийн сургуулийн хүүхдүүдтэй уулзаж байгаа нь. 1995 оны наймдугаар сар.

Тэднийг эргэж ирэхэд Виндзорын ордонд бас нэг шуугиан дэгдсэн байлаа. 1993 оны нэгдүгээр сарын 13-ны лхагва гаригт Английн хэвлэлүүд “Камиллагейт”-ийн асуудлыг сөхөн тавив. Тэд Чарльз болон түүний нууц амраг Камилла Паркер Боулз нарын утсаар ярьсан яриаг илэн далангүй дэлгэжээ. “Намайг гэсэн чиний хайр амжилтанд хүрлээ” гэж Чарльзыг хэлэхэд Камилла “Би чиний төлөө юу ч хийж, ямар ч бэрхшээлийг давж чадна. Энэ бол аугаа их хайр юм. Энэ бол хайр дурлалын гайхамшигт хүч юм” хэмээн хариулж байсан нь тодорхой болов. Энэ яриа 1989 оны арванхоёрдугаар сарын 18-нд өрнөсөн болохыг, энэ бичлэг 1514 үгээс бүтсэнийг нэг их удалгүй тодрууллаа. Дээр нь олон нийтийн анхаарлыг сонин, сэтгүүлдээ хандуулах гэсэн хэвлэлийнхний элдэв таамаг хүрээгээ улам тэлж байв.

Энэ үед Чарльз “Камиллагейт”-ийн асуудал түүнд огт хамаагүй мэт АНУ, Мексикт аялж явав. Харин Галлын хунтайжаас салсан Диана өөрийн шинэ нөхцөл байдалдаа илүү түргэн дасч байлаа. Тухайлбал тэр 1993 оны гуравдугаар сард Балбад очихдоо онгоцны хоёрдугаар зэрэглэлийн суудалд тухалсан юм. Түүнийг буухад улаан хивс дэвссэнгүй, төрийн дуулал эгшиглэсэнгүй.



Хатагтай Диана Челсигийн гимнастикийн клубээс гарч яваа нь.

1997 оны нэгдүгээр сарын 27.

Чарльз, Диана хоёрын хооронд салсан хойноо ч найрсаг харилцаа байсангүй. Жишээлэхэд, Дианагийн эмэг эх, хатан хааны дотны найз нарын нэг Рут Фермоуг хөдөөлүүлэх ёслол 1993 оны зургадугаар сард болсон. Зимбабвед аялж явсан Диана эмэг эхийнхээ нас барсныг дуулаад яаралтай эргэж иржээ. Тэгээд эмэг эхээ Бэкингэмийн цэцэрлэгт хүрээлэн, “Журассик парк”-ын алинд нь оршуулах талаар Чарльзаас зөвлөгөө хүсчээ. Чарльз түүнд Бэкингэмийн хүрээлэнд хөдөөлүүлэх бодолгүй байгаагаа шууд илэрхийлж байлаа.

Хэвлэлийнхэн Дианаг Галлын гүнж байхаас нь илүү ихээр ангуучилдаг болжээ. Зургийг нь янз бүрээр авахыг оролдож, ямар нэг эр хүнтэй холбоотойг нь тогтоох гэж улайрч байлаа. Арга нь барагдсан Диана “Хэвлэл мэдээллийн хамгийн үнэтэй бүтээгдэхүүн нь би юм байна. Би үнэхээр олон хүнийг тэжээж байна шүү” гэж нэгэнтээ хэлж байжээ. Хэдийгээр тэр хааны ордны хатуу хүлээснээс гарсан ч хэвлэлийнхнээс мултарч чадахгүй байлаа. Өөрөөр хэлбэл, тэр жинхэнэ эрх чөлөөг олж авч чадаагүй юм.

1993 оны тавдугаар сард гимнастикийн клубт авсан гэх Дианагийн цуврал зургуудын тухай шуугиан дэгдлээ. Тэдгээр зургийн зарим нь мөн оны арваннэгдүгээр сард хэвлэлд нийтлэгдсэн байна. Энэ зургуудыг гимнастикийн клубийн эзэн, Шинэ Зеландын иргэн Брис Тайлер авсан болох нь тодорхой болов. Тэрбээр Дианагийн хөлийн булчингийн дасгал хийдэг хэрэгслийн дор жижиг хайрцагт гэрэл зургийн аппарат нуун байрлуулж тэдгээр зургийг авсан нь ч илрэв. Зориудын энэ үйлдэл Дианад маш хүнд цохилт боллоо. Тиймээс тэр 1993 оны арванхоёрдугаар сарын 3-ны баасан гаригт хэвлэлийнхэнд хандаж мэдэгдэл хийлээ.

“Би олны хараанд өртөх болсоор 12 жилийг ардаа үдлээ. Миний юу ярьж, юу хийх нь хэвлэлийнхний анхаарлыг татдаг гэдгийг мэддэг болсон. Гэвч миний хувийн амьдралд ичгүүр сонжуургүй хандах нь хэрээс хэтэрлээ. Тиймээс ч би үгээ хэлье гэж бодсон юм.

Надад хийх ажил их бий. Гэвч хамгаас түрүүнд би Уильям, Харри хоёртоо илүү их анхаарал хандуулах ёстой. Тэднийг хайрлаж, халамжилж, юугаар ч дутаахгүй байх нь миний үүрэг. Мөн надад найрсаг хандаж, түшиг болж байсан хатан хаан болон Эдинбургийн бэйст талархаж явдгаа хэлэхийг хүсч байна.

Тиймээс та бүхнийг зүрх сэтгэлээсээ намайг ойлгож, надад бага ч гэсэн тайван байх хугацаа олгоно гэдэгт найдаж байна...”. Энэ бол Дианагийн нулимстай хэлсэн үгийнх нь нэгээхэн хэсэг. Гэвч Дианад ингэлээ гээд тайван амьдрал ирээгүй юм.

Чарльз болон Дианагийн хайр дурлалын романы тухай худал, үнэн элдвийн мэдээлэл сонин, сэтгүүлд тасралтгүй гарсаар л байв. Заримдаа Чарльзын бодлогогүй үгс ч иймэрхүү шуугианыг улам дэвэргэж байлаа. 1994 оны зургадугаар сарын 29-нд “ITV” телевизээр цацсан нэвтрүүлэгт оролцоходоо Чарльз “Би салах хүртлээ гэргийдээ үнэнч байсан. Гэхдээ бидний гэрлэлт хэзээ ч засч үл болох алдаа байсан юм” гэж хэлсэн нь бөөн дуулиан дэгдээв. Бас тэрбээр “Камиллагейт”-ийн асуудал босч ирсний дараа “Хатагтай Камилла Паркер Боулз миний дотны найзуудын нэг мөн. Хэрвээ таны гэр бүл бүтэлгүйтсэн бол та сэтгэлээ тайвшруулахын тулд хамгийн дотны найзууд дээрээ очих нь мэдээж шүү дээ” хэмээн өөрийгөө зөвтгөсөн нь олонд нэг их таалагдаагүй юм.

Тэр ярилцлагаас хойш хэдхэн сарын дараа, тодруулж хэлбэл, аравдугаар сарын 4-нд Диана хэвлэлийнхний овоо хараанд өртлөө. Цэргийн эмч, нэгэн үе Дианаг морь унаж сурахад нь багшилж байсан Жеймс Хэвиттэй хайр сэтгэлийн холбоотой болохыг нь илчилсэн Анна Пастернакийн “Гүнжийн хайр дурлал” гэсэн ном энэ өдөр хэвлэгдэн гарлаа. Жеймс Хэвит 1986-1989 онд Дианатай хайр сэтгэлийн холбоотой байсан хэмээн ярьсныхаа хөлсөнд 25 сая франк авчээ. Ингээж тэр жинхэнэ хударгагүй эр болохоо харуулав.

“Бид бие биенээ харангуугаа л дурласан. Диана гайхамшигтай бүсгүй. Тэр Чарльзаас салж

надтай суухыг маш их хүсч байлаа. Тэр Девонд байх ээжийнд маань нууцаар ирж надтай уулздаг байв. Би хааяа Кенсингтоны ордонд очдог байлаа. Мэдээж Чарльзыг байхгүй үед нь очно. Гурван жилийн турш би тэрний хайрын бурхан нь байлаа. Гэвч тэр намайг хаясан. Учир нь бидний оргилсон хайр түүнд гай болно гэж бодсон юм” гэж Дианагийн амрагаар “тодорсон” Ж.Хэвит сонин сэтгүүлд ярилцлага өгч байлаа.



Хатагтай Дианагийн хилэгнэл. Папарацци нараас тэр байнга бултах хэрэгтэй болдог байв. 1996 оны долдугаар сарын 13.

Дараа жил нь Диана BBC-гийн “Панорама” нэвтрүүлэгт оролцохдоо “Тиймээ, би нөхөртөө үнэнч байгаагүй нь үнэн. Би Хэвитэд хайртай байсан. Гэвч тэр ном хэвлэгдэн гарахад түүнд итгэж байсан хамаг итгэл найдвар минь нуран унасан” гэж хэлсэн юм.

Дианагийн дараагийн нууц амрагаар Английн регбигийн багийн ахлагч Вилл Карлингийг хэвлэлийнхэн тодруулав. Удалгүй Челсигийн гимнастикийн клубийн эзэнтэй Диана байнга уулздаг байсан гэж түүний нарийн бичгийн дарга асан Хилари Райн сэтгүүлчдэд дэлгэлээ. Бүр регбичинтэй 15 сар хамт амьдарсан, хууль ёсоор гэрлэлтээ батлуулсан гэсэн мэдээллүүд ар араасаа хөврөв. Үүнийг нь гэрчлэх хүмүүс рестораны эзэн, буудлын ажилчнаас эхлээд тодорлоо. Диана хайрт залуудаа маш элгэмсэг хандаж байсныг бүгд л харсан гэж ярьцаав.

Үүний дараа үл хөдлөх хөрөнгийн худалдаа эрхэлдэг Кристофер Велли, Пакистаны эмч Хаснат Кан нартай Диана хайр сэтгэлийн холбоотой гэсэн шинэ дуулиан бас үүсгэлээ. Ийнхүү эрх чөлөөтэй болсон эмэгтэйг элдвийн шуугиан тойрсонгүй. Харин Диана үхэхээсээ хэдэн долоо хоногийн өмнө сэтгэлийн холбоотой болсон Эмад /Доди/ Аль Файедыг олноос нуугаагүй юм. Доди бол Египетийн тэрбумтан, Парис дахь Ритц зочид буудал болон “Харродс” сүлжээ дэлгүүрийн эзэн Мохаммед Аль Файедын хүү байлаа.

Хунтайж Чарльз, гүнж Диана хоёрын салалтын албан ёсны баримт бичгийг бүрдүүлэхэд нэлээд хугацаа шаарджээ. 1996 оны хоёрдугаар сарын

28-нд “Галлын гүнж Диана хунтайж Чарльзын гэр бүлээ цуцлуулах албан ёсны хүсэлтийг хүлээж авлаа. Тэдний хүүхдүүд Кенсингтоны ордонд үлдэхээр болов. Диана Галлын гүнжийн нэр төрийг өндөрт өргөж явна гэдэгт итгэлтэй байна” гэсэн мэдээллийг Бэкингэмийн ордноос хэвлэлийнхэнд өгчээ.

Үүний дараа санхүүгийн асуудлыг зохицуулах ажил эхэлсэн байна. Чарльз Дианад 120 сая франк, мөн дээр нь нэмж нарийн бичгийн даргын албаны зардалд жил бүр 3 сая франк өгч байхаар болов. Долоо хоногийн амралтын өдрүүдээр Дианаг хөвгүүдтэйгээ уулзахыг, бас амралтанд хамт явж байхыг зөвшөөрчээ. Ингээд тэднийг албан ёсоор салсныг 1996 оны наймдугаар сарын 28-нд шүүгч Жералд Ангел зарласан байна.

Наймдугаар бүлэг



Сүүлчийн хайр дурлал

Ийнхүү Диана бүрэн эрх чөлөөтэй болж, амьдралынхаа нэгэн шинэ үеийг эхэллээ. 1997 оны зун 36-хан настай Дианад шинэ хайр дурлал ирсэн юм. Тэр зун Мохаммед болон Хейни Аль Файед нар Дианаг хоёр хүүхэдтэйгээ Газар дундын тэнгисийн эрэгт хамт амрахыг урьжээ. Тэд Аль Файедын хувийн онгоцоор долдугаар сарын 11-нд Каннд нисч иржээ. Тэд долоо хоног амрах төлөвлөгөөтэй байв.

Гэвч гүнж хийгээд хэвлэлийнхний муур хулганы хөөцөлдөөн шиг үйл явдал үргэлжилсээр байв. Энэ удаа ч байдал хэвээр. Сент-Тропезын усан буудалд гэрэл зурагчид хэдийнэ шавж, өдөр болгон Дианагийн шинэхэн зургууд Английн болон дэлхийн бусад орны сонин хэвлэлд гарсаар байв. Харин Чарльз энэ үед буюу долдугаар сарын 18-нд Камилла Паркер Боулзын 50 насны ойн үдэшлэгийг Хиггровт зохион байгуулж байлаа.

Долдугаар сарын 19-нд Диана хүүхдүүдийн хамт Сент-Тропезоос Лондонд иржээ. Уильям, Харри хоёр эцэг дээрээ очихоор Балморал руу явж, харин Диана Нортвикийн эмнэлэгт хэвтэж байгаа өвчтэй хүүхдүүд дээр очих төлөвлөгөөтэй байв. Гэвч түүнд харамсалтай мэдээ ирлээ. Дианагийн дотны анд, Италийн нэрт загвар зохион бүтээгч Жанни Версаче хүнд алуулсан байв. Тиймээс Диана ажлын төлөвлөгөөгөө өөрчилж, найзынхаа оршуулах ёслолд оролцохоор Милан руу нисчээ. Диана тэр ёслол дээр нэрт дуучин Элтон Жоны дэргэд сууж таарсан бөгөөд ганцхан сарын дараа өөрт нь эмгэнэлт явдал тохиолдоно гэж яахин тааварлах билээ.

Яг энэ цаг мөчид дэлхий даяар Дианаг 41 настай Доди Аль Файедтай янаг сэтгэлийн холбоотой болсон талаар ид шуугиж байлаа. Тэр хоёрын Парист зугаалж, үнсэлцэж байгаа зургийг нь Италийн гэрэл зурагчин, папарацци Марио Бренна авч чадсанаар энэхүү дурлалын холбоо олонд ил болсон түүхтэй.



Диана наймдугаар сарын 7-нд Италиас буцаж иржээ. Онгоцноос буухад нь л гэрэл зурагчид тосоод зогсч байв. Тэр үдэш Диана Додитой хамт оройн хоол иджээ. Маргааш нь тэр газрын минанд өртсөн хүмүүстэй уулзаж, туслалцаа үзүүлэхээр Босни руу явжээ. Энэ үеэр хэвлэлүүдээр жинхэнэ дуулиан дэгдэж байв. Доди, Диана хоёрын үнсэлцэж байгаа зураг бүх сонин, сэтгүүлийн нүүрийг чимэглэжээ.

Наймдугаар сарын 10-ны ням гарагт “Sunday Mirror” сонин тэдний үнсэлцэж буй анхны зургийг нийтэлжээ. Тэд энэ зургийг папарацци нараас 2.5 сая франкаар худалдаж авсан байна. Үүний дараагаас ийм зургийн үнэ бүр хаданд гарч хамгийн багадаа л 10 сая франкын үнэ хүрч эхэлжээ.

Хэрэг явдал үүгээр дууссангүй Шар хэвлэлүүд дуу дуугаа авалцан Додигийн өмнөх дурлалын романсыг сөхөж эхэллээ. Додигийн холбоотой байсан кино жүжигчин, загвар үзүүлэгч бүсгүйчүүдийн нэрсийн бүхэл бүтэн цуваа гарав. Валери Перрин, Ку Старк, Брук Шилдс, Тина Синатра, Сузан Греггард /1987 онд Доди түүнтэй гэрлээд найман сарын дараа салсан юм/, Жулия Робертс, Жоан Валли гэхчлэн үргэлжилж байлаа.

Наймдугаар сарын 14-нд Лос-Анжелест бас нэгэн үзэсгэлэнт бүсгүй Доди, Диана хоёрын холбооноос үүдэн өмгөөлөгчдөө хандлаа. Түүний нэрийг Келли Фишер гэнэ. АНУ-ын загвар үзүүлэгч, 31 настай Фишер Доди Аль Файедтай сүй тавьсан байжээ. Тэр битгий хэл Доди түүнд очир алмаазан бөгж бэлэглэсэн байлаа. Сүйт бүсгүй итгэлийг нь эвдсэн хархүүгээсээ өшөөгөө авахаар шийдэж, 2.7 сая доллар нэхэн шүүхэд ханджээ. Энэ үйл явдал ид шуугиан тарьж байхад Диана, найз бүсгүй, Лондон дахь “Тиффани” гэдэг үнэт эдлэлийн дэлгүүрийн захирал Роза Монктоны хамт Грек рүү нисчээ. Тэд Эгэйн тэнгист завиар зугаалж амрах зорилготой байв. Тэр хоёр энэ аяллаа зургаан өдрийн дараа дуусгаж, наймдугаар сарын 20-нд Лондонд буцаж иржээ.

Гэвч Дианаг дахин нэг аялал хүлээж байв. Ингээд гүнж маань дахин аяны цүнхээ базааж амраг хайртаа даган Францын өмнөд нутгийг зорьжээ. Тэд

Сент-Тропез, Сент-Жан-Кап-Ферра, Монако, Портофино, Сарден гэсэн чиглэлээр аялсаар

наймдугаар сарын 30-ны бямба гаригийн 15.15 цагт Парист буужээ. Онгоцноос буухад нь л паппараци нар тосч байлаа. Тэд Мохаммед Аль Файедын эзэмшилд байдаг “Ритц” зочид буудалд ажилладаг мэдээлэгч нараасаа энэ тухай сонссон байжээ. Доди, Диана хоёр 16.30 цагт Ритц зочид буудалд ирсэн бөгөөд удалгүй Елисейн талаар зугаалахаар гарчээ. Орой нь тэд буудлын ресторанд хооллоод шөнө дунд болж байхад Арсен-Хоссэйн гудамжинд байдаг Додигийнх руу амрахаар явах болжээ. Буудлын өмнө олон лимузин машин эгнэн, паппараци нар гарах хаалгыг отон зогсож байв. Паппараци нараас зугтахын тулд тэд хар өнгийн “Мерседес 280S” машиндаа гүйх шахам сууцгаалаа. Доди Аль Файед бага зэрэг архи уусан байсан болохоор “Ритц” зочид буудлын хамгаалалтын албаны ажилтан Хэнри Пол жолооны ард суув. Түүний хажууд гүнжийн бие хамгаалагч Тревор Ри-Жонес, арын суудалд Доди, Диана хоёр суужээ.

Тэднийг Конкордын талбай дөнгөж өнгөрч явахад гэрэл зурагчдын машин гүйцэж иржээ. Тэднээс мултрахын тулд Хенри Пол хурдаа огцом нэмсэн байна. Алмагийн хонгилыг чиглэн Сена мөрний эргээр тэд цагт 180 километрийн хурдтай давхиж явжээ. Гэнэт Хенри жолоодлогоо алдсан байна.



Жак болон Бернадет Ширак нар хунтайж Чарльз болон хатагтай Дианагийн хоёр эгч Сара, Жейн нарын хамт. 1997 оны наймдугаар сарын 31. Питие-Салпетриерийн эмнэлгийн өмнө.

“Мерседес” машин Алмагийн хонгилын гурав дахь баганыг мөргөн осолдлоо. Энэ үед 00 цаг 24 минут болж байв. Ингээд аймшигт хором мөчүүд ар араасаа хөвөрч эхлэв. Гурван минутын дараа аюулын дохио өгчээ. Тусламж ч яаралтай ирэв. Эмч нарын баг цаг алдалгүй ирж Дианад анхны тусламж үзүүлэв. Шүүх цагдаагийн газрын дарга Патрик Риу, Гэмт хэрэгтэй тэмцэх газрын дарга Мартин Монтэй, цагдаагийн албан хаагч Филипп Массонни нар ослын газарт хамгийн түрүүнд хүрэлцэн иржээ. Тэднийг ирэхэд долоон паппараци тэнд байжээ. Эвдэрч хэмхэрсэн машинаас гүнжийг арайхийж гаргаж авсан байна.

Яг энэ мөчид Шотландын Балморалд байсан хатан хааны гэр бүлийнхэнд гүнж осолдсон тухай мэдээлэл очиж байлаа. Доди, жолоо барьж явсан Хенри Пол хоёр газар дээрээ нас барж, харин бие хамгаалагч нь маш хүнд шархаджээ. Аврагчид Дианаг яаралтай тээвэрлэж, Питие-Салпетриерийн түргэн тусламж үзүүлэх эмнэлэгт хүргэх нь зүйтэй гэж үзэв. Шөнийн хоёр цагт Дианаг эмнэлэгт хүргэж, сэхээн амьдруулах эмчилгээ хийж эхэллээ. Эмч нар боломжтой бүхнийг хийж байв. Гүнжийн цээжин хэсэг нь хүнд цохилтод өртөж, улмаар их хэмжээний цус алджээ. Ингэснээр зүрхний гүн дутагдалд орсон байна.

Цус тогтоох арга хэмжээ авч, амьсгалын аппарат залгаж, зүрхний үйл ажиллагааг дэмжих эмчилгээ хийсэн ч амжилт олсонгүй байсаар хоёр цагийн дараа Диана нас баржээ. Өөрөөр хэлбэл, наймдугаар сарын 31-ний 04 цагт гүнжийг нас барлаа гэж Францад суугаа Английн элчин сайд, сэр Майкл Жэй Галлын хунтайж, хатан хааны хувийн нарийн бичгийн дарга, Ерөнхий сайд Тони Блейр нарт мэдэгдсэн байна. Үүнээс хойш ойролцоогоор нэг цагийн дараа энэ харамсалт мэдээг телевиз, радиогоор дамжуулж эхэлжээ. Дэлхий даяар хүнд цохилтонд орлоо. Хаа сайгүй гашуудан эмгэнэсэн хүмүүсийн хүрлийсэн царай. Парист Францын Ерөнхийлөгч Жак Ширакын гэргий Бернадет Ширак Галлын гүнжийн шарилын өмнө хамгийн түрүүн ирж толгой бөхийлгөн гүнээ эмгэнэж байв.

Мөн өдрийн үдээс хойш Ерөнхийлөгчийн гэр бүл, Галлын хунтайж Чарльз, Дианагийн хоёр эгч, хатагтай Жэйн Фоллоу, Сара Маккоркодал нар

Питие-Салпетриерийн эмнэлэгт иржээ. Тэд гүнжийн шарилыг Виндзорын ордонд хүргэх зорилготой байв. Энэ ёслолыг харсан олон түмэн нулимстай нүдээр телевизээ ширтэж байлаа.

Яг энэ үед увайгүй сэтгүүлчид гүнжийн талаар бас нэг шуугиант мэдээг хэдийнэ цацаж эхэлсэн байлаа. Тэр нь “Диана жирэмсэн байсан. Түүгээр ч үл барам Доди Аль Файедтай сууж Исламын шашны ёсоор хуримаа хийхээр зэхэж байсан” гэсэн мэдээлэл байв. Гэвч гүнжийн ойр дотны бүх хүн энэ мэдээллийг үгүйсгэсэн юм. Ийнхүү Диана нас барж, ослын шалтгааныг тодруулах асуудал бидний дунд үлдэв. Диана яг л ослоор, эмгэнэлт байдлаар нас барсан Жэймс Дин, Мэрилин Монро, Монакогийн гүнж нар шиг домог болон мөнхөрлөө.

Есдүгээр бүлэг



Оршуулах ёслол

Диана гүнжид ямар хүндэтгэл үзүүлэн оршуулах нь Виндзорын ордны эзний сэтгэлийг шаналгаж байлаа. Ард түмнийхээ сэтгэлийн хөдөлгөөн, дуулиан шуугианыг ч сайтар тооцож үзэх ёстой байв. Кенсингтоны болон Бекингэмийн ордны өмнө хүмүүс маш олноор цугларч, цэцэг тавьж, бас уур хилэнгээ илэрхийлсэн захидлаар дарж байв.

Ням гаригийн өглөөний долоон цагийг хунтайж Чарльз Балморалд хүлээж байлаа. Тэрбээр хоёр хүүдээ эхийнх нь аймшигт үхлийн талаар дуулгах гэж цагийг түгшүүртэй өнгөрөөж байв. Үүний дараа тэрбээр гүнжийн шарилыг авчрахаар Парисыг зорьжээ.

1997 оны есдүгээр сарын 1. Даваа гариг.

Бекингэмийн ордноос Галлын гүнж Дианаг зуурдаар нас барсантай холбогдуулан мэдэгдэл гаргалаа. Парист осолтой холбогдуулсан анхны хэвлэлийн хурал болов. “Ритц” зочид буудлын хамгаалалтын албаны ажилтан Хенри Полын цуснаас 1.75 грамм архи илэрчээ. Тэрбээр осолд орох үедээ 180 километр цагийн хурдтай давхиж явсан болохыг мөн тогтоолоо.

1997 оны есдүгээр сарын 2. Мягмар гариг.

Эмгэнэлт үйл явдал болсон газар дээр зургаан мотоцикльтой зурагчин байсан болохыг хэрэг явдлаас 48 цагийн дараа тогтоов. Бекингэмийн болон Английн Ерөнхий сайдын үйлчилгээний албаныхан гүнжийг хэрхэн оршуулах талаар Дианагийн эцэг гүн Спенсертэй сайтар ярилцжээ. Бямба гаригт Вестминстерийн сүмд болох оршуулах ёслолын төгсгөлд орон даяар нэг минут чимээгүй зогсож гүнжид хүндэтгэл үзүүлэх нь зүйтэй гэж Хатан хааны ордноос шийдвэрлэжээ. Их Британийн иргэд маш олноор гудамжинд гарч Бекингэмийн ордны өмнө цугларан төрийн далбааг яагаад бөхийлгөхгүй байгаад хачирхаж байв. Хааны ордны тогтсон жишгээр бол хатан хааны байгаа газарт далбааг мандуулдаг ёстой. Энэ үед

тэрбээр Балморалд байсаар байлаа.

1997 оны есдүгээр сарын 3. Лхагва гариг.

Хатан хаан болон түүний гэр бүлийнхэн огт чимээгүй, Балморалд бүгсээр байгаад олон нийт дургүйцлээ илэрхийлэх нь хурцадлаа. Галлын хунтайжийн нарийн бичгийн дарга нарын албанаас “Хатан хааны гэр бүл, Галлын хунтайж Чарльз, Уильям болон Харри нарт гэнэтийн хүнд цохилтоос гарахад хугацаа хэрэгтэй байна. Тэд маш их сэтгэлийн хямралд ороод байна” гэж мэдэгдэв.

Ерөнхий сайдын албанаас энэ өдөр олон түмэнд хандаж “Оршуулах ёслолтой холбогдуулан олон асуудал урган гарч байна. Энэ бүхэнд тэд оролцож байгаа. Хоёр хүүг нь тайвшруулах гэж одоо ч янз бүрийн арга чарга хэрэглэж байгаа. Бидэнд тохиолдсон гай зовлон тэдэнд бүр хүндээр тусч байна. Тиймээс бид тэднийг хүндэтгэх ёстой” хэмээн хэлжээ.

1997 оны есдүгээр сарын 4. Пүрэв гариг.



Гүнжийн шарилыг зургаан хар морь хөллөсөн сүйх тэргэнд залсан байв.



Хунтайж Чарльз, ханхүү Уильям, Харри, гүн Спенсер, Эдинбургийн бэйс нар гүнжсийн шарилд хүндэтгэл үзүүлж буй нь.

“Манай хатан хаан, манай төрийн далбаа хаана байна” гэсэн өгүүлбэрийг Их Британийн хэвлэлүүд том үсгээр толгойлон хэвлэлээ. Энэ асуултын хариуг тэр дор нь өгөөгүй юм. Гэхдээ хатан хаан баасан гаригт Лондонд ирж Дианагийн шарилд мэхийж, ард түмэндээ хандаж оршуулах ёслол дуустал Бекингэмийн ордны дээрх төрийн далбааг бөхийлгөнө хэмээн мэдэгдсэн билээ.

Мөн өдрийн үдээс хойш Уоркын бэйс болон түүний дүү хунтайж Эдвард нар Лондонд ирж, эхлээд эмгэнэлийн дэвтэрт гарын үсгээ зурахаар

Сент-Жэймсийн ордныг зорьжээ. Тэд дараа нь цугларсан олонтой харуусал эмгэнэлээ хуваалцаад Бекингэмийн ордонд явганаар ирсэн байна. Яг энэ цаг мөчид хатан хаан Балморалд Дианагийн дурсгалд зориулсан мөргөлийн ёслолд оролцож байлаа. Хатан хааныг түүний нөхөр, Эдинбургийн бэйс Филипп, хунтайж Чарльз, Уильям, Харри нар дагалдсан байв. Тэд мөргөлд оролцохын зэрэгцээ цайзын хайсын өмнө тавсан цэцгэн дундах элдэв бичгийг үзэж явав. Чарльз бага хүү Харригийнхаа гараас хөтлөн түүнд сэтгэлийн дэмжлэг үзүүлж, Дианад хандсан зүрх сэтгэлийн үгсийг уншиж өгч байлаа.

1997 оны есдүгээр сарын 6. Баасан гариг.

“Хатан хаан ард түмнийхээ өмнө толгой бөхийлгөх ёстой” хэмээн хэвлэлийнхэн нилээд

хилэнтэй бичиж, ярих боллоо. Мөн өдөр хатан хаан Балморалаас Лондонд ирж өөрийн нөхөр Филиппийн хамт Бекингэмийн ордны өмнө цугларсан олон мянган хүмүүсийн дундуур явж, тавьсан цэцэг, зурвас, ил захидал зэрэгтэй танилцаж, зарим хүнтэй цөөн үг солилоо. Харин хунтайж Чарльз хоёр хүүгийнхээ хамт зэргэлдээ нь орших Кенсингтоны ордны өмнө цугларсан хүмүүстэй уулзаж байв. Олон түмний баргар царай арай гийжээ. Оройны 18 цагт Элизабет II хар өнгийн эмгэнэлийн хувцас өмсөн телевизийн дэлгэцээр гарч ард түмэндээ хандан үг хэллээ. Дараа нь хатан хаан Сент-Жэймсийн ордонд ирж час улаан сарнай цэцгийн баглааг Дианагийн шарилын өмнө тавилаа. Орой нь гүнжийн шарилыг Сент-Жэймсийн ордноос Кенсингтоны ордонд тусгай зориулалтын тэргээр зөөвөрлөн авчирлаа. Энэ үед Галлын хунтайж хоёр хүүгийн хамт, мөн Спенсерийн гэр бүлийнхэн дагалдан явж байв.



Нэрт дуучин Лучиано Паваротти гэргий Николеттагийн хамт дотны андынхаа оршуулах ёслолд оролцлоо.



Хайрт эгчийнхээ дурсгалд зориулсан дүү Спенсерийн зүрх сэтгэлийн үгсийг сонссон хүмүүс нулимсаа барьж тэвчихгүй байв.

1997 оны есдүгээр сарын 6. Бямба гариг.

Ард түмний гүнж Дианаг сүүлчийн замд нь үдэх энэ өдрийн тэнгэр маш тунгалаг, нартай сайхан байв. Дианаг сүүлчийн замд нь үдэхээр ирэх олныг зохицуулахаар хамгаалалтынхан хар үүрээр ажилдаа гарчээ. Гүнжийг оршуулах ёслолд оролцохоор ойролцоогоор хоёр сая британчууд цугларчээ. 1965 онд Ерөнхий сайд асан Уинстон Черчиллийг оршуулахад л нэг удаа ийм олон хүн цугларч байсан гэдэг.

09 цаг 08 минут.

Зургаан хар морь хөлөглөсөн, 22 цэргээр хамгаалуулсан сүйх тэргэнд гүнжийн шарилыг тавин Кенсингтоны ордноос хөдөллөө.

Вестминстерийн сүм, Кенсингтоны цэцэрлэгт хүрээлэнд цугласан олон мянган хүний гашуудлын хийгээд уйлах дуу хавь ойрыг цочроож байлаа. Гүнжийн шарил дээр гурван өнгийн баглаа цэцэг тавьжээ. Тэр гурван цэцгийг Уильям, Харри болон гүнжийн эцэг Спенсер нар тавьжээ.

Гудамжинд хүмүүсийн гашуудлын дуу улам нэмэгдэж байв. Уйлсан, гашуудсан хүмүүсийн хашгираан, “Бурхан түүнийг өршөөгөөч” хэмээх ерөөл, шарил зөөж яваа морьдын хөл доор зөөллөх гэсэн мэт завсаргүй шидэх цэцэгс. Энэ цаг мөчийг хэдхэн үгээр зураглавал ийм л

байлаа.

10 цаг 15 минут.

Хатан хаан Элизабет Виндзорын ордныхныгоо дагуулан эмгэнэлт ёслолд оролцохоор Бэкингэмийн ордны өмнө гарч ирлээ. Удалгүй гүн Спенсер, хоёр ач хүүтэйгээ, араас нь хунтайж Чарльз, Эдинбургийн бэйс нар гарч ирэв. Уильям толгойгоо унжуулан, нүүрээ халхалж, уруулаа тас жимийжээ.

11 цаг.

Шарилыг Вестминстерийн сүмд байрлууллаа. Хатан хааныг тойрон хааны гэр бүлийн 46 хүн эмгэнэл илэрхийлэхээр зогсчээ. Гүнжийн оршуулгад оролцохоор 2000 гаруй хүндэт зочид ирсэн байв. Гүнжийн олон талт үйл ажиллагаа эрхэлж байсны илрэл болж улстөрчид, дуучид, загвар зохион бүтээгчид, шоу бизнесийн алдартнууд хүрэлцэн иржээ. Хиллари Клинтон, Бернадет Ширак, Голландын гүнж Маргаритет, Францын Ерөнхийлөгч асан Жискард Д'Эстен, нэрт загвар зохион бүтээгч Карл Лагерфельд, Валентина болон Версачегийн гэр бүлийнхэн, дуучин Элтон Жон, Стинг, Жорж Майкл, Лучиано Паваротти, жүжигчин Том Круз, Николь Кидман, Том Хэнкс, найруулагч Стивен Спилберг ... Ингээд нэрлээд байвал дуусахгүй олон алдартан ирсэн байлаа.



Эхлээд Уэсли Карр Дианагийн сонсох дуртай дууны нэг, 1981 онд гэрлэх үеэр нь дуулж байсан “ I vow to thee, my country” дууг намуухан эгшиглүүлэв. Удаа нь Дианагийн хоёр эгч, хатагтай Сара, Жэйн нар эмгэнэлийн үг хэллээ. Тэдний дараа Их Британийн Ерөнхий сайд Тони Блейр индрийг зорилоо. Тэрбээр “Их Британи төдийгүй дэлхий нийтээрээ гүнжид хайртай байсан юм. Түүний явуулж байсан хүмүүнлэгийн үйл ажиллагааг хэн ч мартаж өсгүй” хэмээн хэлэв.

Тони Блейрийн санааг гүнзгийрүүлэн Кантербурийн хамба лам Кэри “Бусдын төлөө гэсэн Дианагийн энэрэнгүй нинж сэтгэл үнэхээр гайхамшигтай” гэж хэллээ.

“Hyde park”-д цларч асар том дэлгэцээр гүнжтэй салах ёс гүйцэтгэх ажиллагааг харж байсан

олон түмэн Элтон Жоны дуулсан “Английн сарнай минь үүрд баяртай” дууг сонсоод бүр ч их эмгэнэн гашуудлаа. Үйл явдлын оргил нь Дианагийн дүү, гүн Спенсерийн эгчдээ зориулан хэлсэн хүндлэл гашуудлын үг байлаа. Түүнд гомдол цөхрөл, уур хилэнгээ илэрхийлэхэд, Британийн ард түмний нэгэн үзүүрт бодол санааг багцлан гаргахад чухамхүү үг л дутаж байх шиг байв. Вестминстерийн сүмийн гадна цугласан хүмүүс түүний өгүүлбэр бүрийн дараа гүн Спенсертэй санаа бодол нэг байгаагаа илэрхийлэн алга ташиж байв.

Эцэс нь Кантербурийн хамба лам мөргөлийн үгсийг хэллээ. Галлын гүнж Дианагийн төлөө, түүний сайхан сэтгэл, энэрэнгүй нинжин сэтгэлийн төлөө бурхан танд залбиран мөргөж байна. Хүнд өвчтэй хүүхдүүдийн төлөө, аймшигт ДОХ өвчин туссан асар олон залуусын төлөө хийсэн Дианагийн хүмүүнлэгийн буянт үйлсийг бид хэзээ ч мартажгүй ээ... гэж хамба ламтан мөргөлөө.



Гүнж Диана хамгийн дотны анд, нэрт дуучин Элтон Жоны хамт.

12 цаг 05 минут.

Шашны зан үйлийн дараа бүх хүн нэг минут чимээгүй зогсож хүндэтгэл үзүүлэв. Дараа нь хүндэт зочид Дианагийн шарилыг тойрон хүндэтгэл үзүүлжээ. Тэгээд Лондонгоос 120 километрийн зайд орших, Гүн Спенсерийн эдлэн газар болох Алторпэд гүнжийн шарилыг хүргэхээр хөдөөлүүлэх машинд байрлууллаа.

Чухамхүү тэр газарт, Овал нуурын дунд байх бяцхан арал дээр Диана үүрд нойрссон юм. Амгалан тайван тийм газар нутаг, орон зайг тэр амьд ахуйдаа асар ихээр хүсэн мөрөөддөг байсан билээ.

Table of Contents

[Оршил бүлэг](#)

[Тэргүүн бүлэг. Бага, өсвөр нас](#)

[Дэд бүлэг. Эрин зууны гэрлэлт](#)

[Гутгаар бүлэг. Хааны хүүхдүүд](#)

[Дөтгөөр бүлэг. Дианаг бишрэх үзэл](#)

[Тавдугаар бүлэг. Зөрчил](#)

[Зургадугаар бүлэг. Зүрх сэтгэлийн Хатан хаан](#)

[Долдугаар бүлэг. Эрх чөлөөт бүсгүй](#)

[Наймдугаар бүлэг. Сүүлчийн хайр дурлал](#)

[Есдүгээр бүлэг. Оршуулах ёслол](#)